# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 01 өдөр　　　　Дугаар А/305　　　　Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал
эрүүл ахуйн зааварчилгаа батлах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 27 дугаар зүйлийн 27.3.1, 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ

1.Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын ажилтан албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэх явцдаа аливаа учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг хавсралтаар баталсугай.

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг албан хаагчдад, журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Тамгын газрын хэлтэс, алба болон хорооны Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Энэхүү зааварчилгааг албан хаагчдад танилцуулан тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж ахуйн алба (Л.Отгонбаяр)-нд үүрэг болгосугай.

4.Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/105 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА　　　　Б.МӨНГӨНХУЯГ

9023030504
9068822 СЕТ23057

1620061184

Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны ... дугээр сарын ...-ны өдрийн ...... дугаар тушаалын хавсралт
А/305

# АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

## Нэг. Нийтлэг үндэслэл

Байгууллагын ажилчид ажил гүйцэтгэх үед гарч болох ямар нэгэн аюул ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй дадлыг тогтоох зорилгоор “Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г дагаж мөрдөнө.

Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журам Галын аюулгүй ажиллагааны журам болон бусад хууль тогтоомжийг даган мөрдөх нь өөрийгөө болон бусдыг гэмтээхээс, өмч хөрөнгө үрэгдэхээс хамгаалах үндсэн арга байх юм.

Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг доор дурдсан бичиг баримтыг үндэслэн боловсруулав.

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал Эрүүл ахуйн тухай хууль, Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага MNS 4996:2000; Дэлгэц буюу тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуйн шаардлага MNS 4930:2000, эргономикийн зарчим MNS ISO 6385:2000, Өргөх зөөх ачааны массын хэмжээ MNS 4970:2023, Хөдөлмөрийн аюлгүй ажиллагаа эрүүл ахуй, Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000; Байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын зааварчилгаа болон бусад хууль тогтоомжуудыг үндэслэв.

## Хоёр. Хамрах хүрээ

2.1.Энэхүү зааварчилгааг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар газрын үйл ажиллагаанд ашиглах бөгөөд байгууллагад ажиллаж байгаа харьяа, хэлтэс, тасаг алба, хороодын ажилтан дагаж мөрдөх ажлын байрны нөхцөл байдлаас шалтгаалан засвар өөрчлөлт нэмэлтээр оруулан баталж мөрдөх болно.

2.2.Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс,тасаг, харьяа хэлтэс албадын албан хаагчид шинээр буюу түр зуурын чанартай ажил ажилтнаар гүйцэтгүүлэх бол энэхүү аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, гарын үсгээр баталгаажуулсан байна.

## Гурав. Ажлын байранд тавигдах шаардлага

3.1.Зай талбай:Нэг ажилтаны ажлын байрны зай талбайн тавилга хэрэгслээ оролцуулаад $6м^2$–аас багагүй байх нь зохимжтой.

3.2.Шуугианы түвшин оффисын стандартад заасны дагуу байна.

3.3.Тасалгааны дулааныг өрөөний доторх тавилга, түүний байрлалтай уялдуулан зохицуулах шаардлагатай. Ийм тохиолдолд нэмэлт цонх, шилэн хаалт, халаалтын техник, агааржуулах хэрэгслээр зохицуулна.

3.4.Чийгшилт:Агаарыг шүүх, чийгшилтийг тохируулах. Оффисын ажлын байрны агаарын харьцангуй чийгшилт 40-60 хувь байна. Харьцангуй чийгшилт бага байх үед нүд аргах, хамар ам хуурайшиж хатна. Харин харьцангуй чийгшилт их байх үед бүгчимдэх,ядрах, нозоорох зэрэг сөрөг нөлөөтэй.

3.5.Агааржуулалт:Өрөөг хангалттай сайн агааржуулж байх хэрэгтэй. Өрөөг байгалийн эсвэл нэмэлт системээр агааржуулж болно. Албан тасалгаанд цонх хаалгыг нээж хангалттай агаар оруулж болно. Механик агааржуулагч болон сэнсийг байнга шалгаж нян бусад биет үржихээс сэргийлж цэвэр байлгах хэрэгтэй.

Тамхины утаагүй орчин бүрдүүлж, зөвхөн тамхи татах цэгт тамхийг татах ёстой.

Архивын өрөөнд ажиллаж буй ажилтан маск заавал хэрэглэнэ.

3.6.Өвчлөл үүсгэх хам шинж ямар нэгэн тодорхой шалтгаан тогтоогдохгүйгээр нүд өвдөх, нус гоожих, толгой өвдөх, эргэх, арьс хуурайших, салстлаг хальс цочрох, дотор муухайрах шинж тэмдэг илрэх тохиолдол байдаг. Үүнээс сэргийлэхийн тулд аргааржуулалтыг системийг зөв байрлуулж хангалттай агааржуулах, чийгшилт, гэрэл зэргийг тохируулах. Ажлын зохион байгуулалт хуваарь дэг зэрэг сэтгэл зүйд нөлөөлөх стресст орохгүйн тулд хувийн зохион байгуулалттай байна.

3.7.Гэрэлтүүлэг: Ажлын байр нь байгалийн ба зохиомол гэрэлтүүлэгтэй байна.

3.8.Байгалийн гэрэлтүүлэгтэй үед нарны гэрлийн шууд тусгалыг сарниулах хөшигтэй байх, нүдэнд шууд тусч гялбахааргүй байна.

3.9.Зохиомол гэрэлтүүлэгтэй үед гэрэлтүүлэг нь жигд тархсан нүдэнд шууд тусахгүй, гялбалт үүсгэхгүй, ашиглахад хялбар байх бөгөөд гэрлийн шилийг байнга цэвэрлэж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх ёстой.

Шат, хонгил агуулах зэрэг нь заавал гэрэлтүүлэгтэй байх ёстой.

3.9.Оффисын цайны газар ажлын хувцас, гадуур хувцастай үйлчлүүлэхийг хориглоно.

3.10.Өдөр тутам чийгтэй цэвэрлэгээ хийгдсэн байна.

3.11.Гал унтраагуурыг галын аюулгүй ажиллагааны журмын дагуу ил газар байрлуулна.

3.12.Аваарын хаалга, гарц, шат чөлөөтэй, тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

Дөрөв. Ажил эхлэх өмнөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа

4.1.Ажил эхлэхээс өмнө ажлын байрыг цэвэрлэсэн байна. /үйлчилгээний ажилчид/

4.2.Ажилчид ажлын байран дахь агааржуулалт, цэвэрлэгээ хийгдсэн эсэх, гэрэлтүүлэг хэвийн эсэх, тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж байна.

4.3.Ажлын байранд тавигддаг ширээ сандлын бүрэн бүтэн байдал, цахилгааны утас, залгуур, разетик, унтраагуур, тоног төхөөрөмжүүд зэргийг гадна талаас нь харж шалгах хэрэгтэй. Цахилгааны утас хамгаалалтгүй ил байж болохгүй.

4.4.Компьютер болон бусад төхөөрөмжийн ойр орчимд хоол унд, хүнсний зүйл байх ёсгүй.

4.5.Цонхны шил бариул бүрэн бүтэн байдал, хаалганы түгжээ хэвийн эсэхийг шалгаж байх хэрэгтэй. Эвдрэл гэмтэл илэрвэл хариуцсан хүнд нь мэдэгдэж аюулгүй болгох.

4.6.Ажлын өрөө тасалгаанд согтууруулах ундаа хэрэглэсэн хүнийг ажиллуулахгүй байх.

4.7.Цаас зүсэгч, үдээсний машин, үдээс авагч, хайч зэргийг ашиглахдаа болгоомжтой ажиллах

4.8.Ширээний эмх цэгцтэй байдлыг хангаж ажиллаж дээр нь юм овоолохгүй байх.

4.9.Ширээний өндөр нь сандал дээр сууж байхад тохойн түвшинд байх

4.10.Ажилчид өөрсдийн өрөөний өнгө үзэмж, цэвэр цэмцгэр байдалд санаа тавьж өөрийн тав тухыг хангаж ажиллах бөгөөд шаардлагатай зүйлс гарвал холбогдох харьяа хэлтсээс гаргуулан авах.

Тав. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Компьютер дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

5.1.Асаалттай компьютерын дэлгэцнээ рентген туяа ялгардаг учраас дэлгэцээ хараанаасаа дор хаяж 40см –ын хол байна.

5.2. Компьютер хоорондох зай 1,2 метрийн зайтай байх ёстой. Үүнээс ойр байвал соронзон орны талбайн хамрах хүрээ ихэсдэг. Мөн хананаас 60см зайтай байрлуулах ёстой.

5.3.Компьютер дээр ажиллаж байх үедээ хоёр цаг тутамд 15 минут амардаг байх
5.4.Суухад тохиромжтой ширээ, сандал ашиглах. Сандал дээр бүрэн суух.
5.5.Нуруугаа байнга бөхийлгөхгүй байхаар ажлаа зөв зохион байгуулах.
5.6.Нүдний түвшин 5-8см мониторoос илүү гарсан байх.
5.7.Хэрэв шүүлтүүргүй дэлгэц ашигладаг бол оптик шил хэрэглэж байх.
5.8.Дэлгэцээс сунгасан гарын хэмжээнд суух.
5.9.Хөл шаланд тавхайгаар хүрсэн байх.
5.10.Зөөврийн компьютерыг өвөр дээрээ тавьж ажиллахгүй байх.
5.11.Дэлгэц дээр тоос шороо, хир буртаг, хуруунЫ хээ огтхон ч байх ёсгүй.
5.12.Ажиллаж байгаа компьютерын металл хэсэгт хүрэхгүй байх.

Принтертэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

5.13.Зөөврийн хэвлэгч машинтай ажлын байранд агааржуулалтын системтэй байх эсвэл тогтмол салхилуулж чийгтэй цэвэрлэгээ хийх.

5.14.Хувилагч техник дээр жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ажиллуулахыг хориглоно.

5.15.Хувилагч техник хэрэглэдэг хорноос ялгарах тоосонцор агаарт 3,5кв/$м^3$ с бага байх ёстой.

5.16.Хувилагч техник хана баганаас 0,6 метрээс, үйлчлэх зай 1 метрээс багагүй байх шаардлагатай.

5.17.Хувилагч техникийн озоны шүүлтүүрийн зөв сонгож тавих, түүнийг байнга шалгаж байх хэрэгтэй.

5.19.Хувилагч техникийн хаалт тагийг байнга шалгаж байх хэрэгтэй.

5.20.Хувилагч техникийг агааржуулах системтэй эсвэл агаар солилцох боломжоор хангагдсан өрөөнд байрлуулах хэрэгтэй./Принтерийн туяаг харсан хүн эргэж сэргээгдэхгүйгээр хараагүй болох талтай тул олшруулагчийн хор буюу тенор гэх бодисыг асар болгоомжтой хэрэглэх ёстой. Тэр бодис амьсгалын замын эрхтнүүдийг өвчлүүлэхээс гадна уушгинд орж амьсгалын сувгийг шууд бөглөдөг аюултай. Иймээс өрөөндөө сэгсэрч хэрэглэхгүй байх/

5.20.Ажиллаж байгаа аппарат, техник хэрэгслийг эзэнгүй орхих, гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглахгүй байх.

5.21.Цахилгаан тоног төхөөрөмж, аппарат, техник хэрэгсэл дээр даавуу, цаас, цавуу зэрэг хялбар шатах материал тавихгүй байх.

5.22.Ажлын өрөө тасалгаа, хадгаламжийн санд тамхи татах, ил гал гаргахгүй байх.

Зургаа. Ажлын байранд зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

6.1.Халитрах, тээглэх, унах, бүдрэх, гар хөлөө хавчуулах, автын хөдөлгөөний аюулаас сэргийлнэ. Үүнд:
6.2.Хуйларсан шалны дэвсгэрийг засах
6.3.Тэгш бус гадарга дээр болгоомжтой явах
6.4.Зам хөндлөн гарахдаа анхааралтай явах, ногоон гэрлээр гарах, явган хүний гарцаар гарах
6.5.Хүчтэй салхинд хаалга савах аюултай салхи шуургатай үед хаалга үүдээр орохдоо болгоомжтой байх
6.6.Ажлын хэсгээ цэвэр байлгах /чийгтэй хальтаргаатай, гадаргыг үйлчлэгчид хэлж арчуулах
6.7.Сэтгүүл, цаас зэрэг багц замбараагүй эд зүйлс байлгахгүй байх
6.8.Уртасгагч утсыг эмх цэгцтэй байрлуулах, явах хэсгээс утсыг холдуулах, ил байгаа цахилгааны утсыг далдлах
6.9.Зохимжгүй гутал өмсөхгүй байх анхаарал хандуулах
6.10. Ажлын хэсгийг гэрэлтэй байлгах

6.11.Гэрлийн шилийг өөрөө дур мэдэн солихгүй байх, мэргэжлийн цахилгаан чинь дуудах

6.12.Тавилга, тоног төхөөрөмжийг ажлын байрны явах хэсэгт саадгүй зохион байгуулах

6.13.Тээглэж унах эрсдэлтэй тул унших зуур алхахгүй байх

6.14. Явдал дундаа шингэн зүйл ууж явахгүй байх

6.15. Шүүгээ, өндөр тавиураас юм авахдаа дугуйтай сандал дээр гарч авахгүй байх

6.16. Шүүгээний хаалга, ширээний шургуулгыг хааж байх

6.17.Үйлчлэгч шал цэвэрлэж байхдаа анхааруулсан тэмдэг ашиглаж байхНойтон шалан дээр болгоомжтой зорчих

6.18.Хүний хөлд цэвэрлэгээний хувин зэрэг ажлын багаж хэрэгслийг ил орхихгүй байх

Шатаар өгсөж уруудаж явах үеийн зааварчилгаа

Шатны бариул эсвэл хамгаалалтын бариулыг шаардлагатай үед хэрэглэх

6.16.Бариулууд дээр суухгүй байх

6.17.Шатыг гишгүүр бүрээр ашиглах

6.18.Чийгтэй, нойтон шатаар явахдаа анхааралтай байх, шаардлагатай тохиолдолд үйлчлэгчид хэлж арчуулах

6.19.Плита шатаар явахдаа халтирахаас болгоомжлох

Долоо. Ажлын байранд дахь ая тух стресст орохгүй байх зааварчилгаа

7.1.Ажлын орчноо тав тухтай байлгахын тулд бусадтай аль болох хамтран ажиллах

7.2.Зохион байгуулалтай байх-Ажил үүргийн жагсаалт гарган хийж дуустал нь тэмдэглэх

7.3.Амралт авах,суниах байрлалаа тогтмол өөрчлөх

7.4.Биеэ амрах – Хэвлийн хэсгээр амьсгалж, мөрөө суллаж бүх суллах

7.5.Тайван эерэг үзэл бодолтой байх- Сөрөг бодлоос зайлсхийх, Хэлтэс албадаас зохион байгуулж буй өглөөний сургалтад хамрагдах

7.6.Стрессийг багасгахын тулд эм уухгүй байх

7.7.Хоол унд, амралтаа зохицуулах.

7.8.Ус байнга уух, цагийн хуваарын дагуу унданд орох

7.9.Ажлыг байрыг эмх цэгцтэй байлгах

Найм. Ажлын байранд гараар ачаа өргөх, зөөх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

8.1.Хөлийн зөв байрлал - нэг хөл нь тухайн ачааг зөөх гэж байгаа зам руу чиглэсэн байхад нөгөө хөл нь биеийг урагш түлхэж болохуйц байрлалд байна

8.2.Цэх шулуун нуруу – ачааг нуруу нь дээрээ зөөх үед нуруу бөхийж бүсэлхий орчмын булчингийн хүчдэл ихсэх, нурууны нугалам хоорондын зайнд хасах даралт үүсдэг тул бага бөхийж даралтыг багасгах

8.3.Гар биед ойр байх – гар аль болох чигээрээ биед ойр байх чухал

8.4.Зөв барих – ачаа гараас мултрах, гулсахаас урьдчилан сэргийлэх, булчингийн ачааллыг багасгах зорилгоор гарынхаа бүтэн алгаар ачааг хөдөлгөөнгүй барих хэрэгтэй

8.5.Биеийн жингийн хэрэглээ – хөл биеийн бөхийлт, өвдөгний сунгалт, биеийн жингийн байрлал зөв байх нь ачааг түлхэх, татах, явган болон тэргээр ачааг зөөхөд чухал ач холбогдолтой

8.6.Архивд ажилладаг ажилтан ачааг зөөхдөө түрдэг тэрэг ашиглах

8.7.Овор ихтэй ачаа зөөхдөө урдах замаа харж болохоор хэмжээгээр зөөх. Овоолж зөөхгүй байх

8.9.Хаалганд хавчуулагдах, цохиулах , хаалга савах зэрэг эрсдэлд өртөх боломжтой тул байнга анхаарал болгоомжтой байх

Ес. Цахилгааны хэрэгсэлтэй ажиллах үеийн зааварчилгаа

9.1.Цахилгаан хэрэгслийг тогтмол шалгаж, зохистой хэрэглэх
9.2.Цахилгааны асуудлыг дор бүр нь холбогдох хүмүүст мэдэгдэх
9.3.Цахилгаан хэрэгсэлд шингэн зүйл хүргэхгүй байх
9.4.Чийгтэй гараар цахилгаан тоног төхөөрөмж разитканд хүрэхгүй байх
9.5.Зөвшөөрөгдөөгүй тоног хэрэгсэл хэрэглэхгүй байх
9.6.Хэрэглээгүй үед цахилгаан хэрэгслийг салгаж байх
9.7.Цахилгаан залгуурыг ашиглаагүй үед салгах
9.8.Цахилгааны залгуурыг хэт ачаалахгүй байх
9.9.Уртасгагч утсыг хивсний доогуур эсвэл явган гарцаар хөндлөн байрлуулахгүй байх
9.10.Утас, кабельд тээглэх аюулаас сэргийлэХ
9.11.Гал гарах эх үүсвэр болох учраас хоёр уртасгагч утсыг ороолцолдуулахгүй байх.
9.12.Урт хугацаанд уртасгагч утас хэрэгтэй бол байнгын цахилгаан утас шаардлагатай
9.13.Төхөөрөмжийг хэт удаанаар, урт хугацааны турш ажиллуулахгүй байх
9.14.Залгуурыг салгахдаа цахилгаан хүчдэлийг сайтар харж залгах ба салгахдаа залгуурын сууринаас барьж залгуурыг салгах хэрэгтэй
9.15.Чийгтэй гараар залгуурыг салгах, залгахгүй байх
9.16.Ургамал услахдаа залгуур, уртасгагч руу ус орохоос болгоомжлох

Арав. Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагаа:

10.1.Албан тасалгааны бүх цахилгаан хэрэгслүүдийг цахилгааны тэжээлээс салгаж болзошгүй аюулаас сэргийлнэ.
10.2.Албан тасалгааны агааржуулагч, салхивч, халаагуурын аюулгүй ажиллагааг шалгана. Өрөө тасалгаагаа цоожилж, лацадна, нэг хувь түлхүүрийг жижүүрт орхих.
10.3.Шатаар буухдаа шатны бариулаас барьж гишгүүрт хөлийн улыг бүрэн гишгэж шатан дээр халтирахаас сэргийлж, болгоомжтой бууна.
10.4.Цахилгаан шатанд суухдаа хэвийн ажиллаж байгааг урьдчилан шалгаж, хаалга бүрэн нээгдсэний дараа сууна.
10.5.Ажилдаа ирж очихдоо аюулгүй, баталгаажуулсан маршрутыг сонгон аюулгүй байдлаа ханган зорчино.
10.6 Галын анхан шатны багаж хэрэгслийг ашиглах, гал унтраагуурын төхөөрөмжийг ажиллуулах чадвартай байна.

Арван нэг. Уртасгагч залгууртай ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

11.1.Уртасгагч залгуурыг цахилгаанаас салгахдаа кабелиас нь татаж болохгүй.
11.2.Уртасгагч кабелиар цахилгааны байнгын буюу суурин утсыг орлуулж болохгүй. /Байшингийн хана туургнад хадаж тогтоож болохгүй./
11.3.Цахилгааны залгуурыг уртасгахын тулд зориулалтын бүтэн бүтэн ажиллагаатай уртасгагч ашиглах бөгөөд зориулалтын бус кабель холбохыг хориглоно.Залгасан уртасгагч болон хэт урт уртасгагч нь хүчдэлийн хэмжээг бууруулдаг бөгөөд багаж, төхөөрөмжийг гэмтээж болох аюултайг анхаарах.
11.4.Уян кабель болон цахилгааны утсыг шалбарах, гэмтэхээс хамгаалах, доторх утаснуудыг тусгаарладаг бүрээс нь зүсэгдсэн, урагдсан, цуурсан эсэхийг байнга шалгаж байх.

11. 5.Ил монтаж хийсэн цахилгааны утас нь ороолцолдох, бүдэрч унах аюултай тул цахилгааны утсыг үүдний ерөө, хана, цонх, тааз, шалан дээгүүр хөндлөн татаж болохгүй.

11.6.Мэргэжлийн болон зөвшөөрөлтэй хүн уртасгагч утсыг засах, кабелийг солино.

Арван хоёр Ослын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

12.1.Аюултай онцгой нөхцөл байдал үүссэн нөхцөлд "Онцгой байдлын төлөвлөгөө"-г дагаж мөрдөх, аль болох сандрахгүй тайван байх

12.2.Нүүлгэн шилжүүлэх гарц, шуурганаас сэргийлэх байр, тэсрэх зүйлийн аюулаас сэргийлэх зэрэг мэдээлэлтэй байна.

12.3.Гал гарсан нөхцөлд

12.4.Гарах хаалгыг түгжихгүй эсвэл хаахгүй байх

12.3.Урьдчилан аюулгүйн гарцыг мэдэх

12.4.102 луу утасдах

12.5. Нүүлгэн шилжүүлэх гарц, цугларах цэгийг мэддэг байх

Арван гурав. Гурав бусад

13.1.Ажилтан та ажилдаа согтууруулах ундааны зүйл хэрэглэж ирэхгүй байх. Ажлын байранд архи болон тамхи мөн электрон тамхи хэрэглэхгүй байх.

13.2.Ажилтан таны биеийн байдал тавгүйрхэх, хөнгөн гэмтэл авсан үед зохион байгуулалттай нэгжид байрших эмийн сан болон эмчийн өрөөнд очиж анхны тусламж авна.

13.4.Гадуур ажил үүргээ гүйцэтгэж явахдаа гадуур ажлын программ дээр ажлын зорилгоо тэмдэглэн аюулгүй ажиллагааны заавартай танилцан гарын үсэг зурж баталгаажуулна.

13.5.Байгууллагын ойр орчимд байрлах анхааруулах тэмдэг тэмдэглэгээг анхаарч ажиглаж байх

13.6.Байгууллагын ойр орчимд байрлах цахилгаан шит,трансформатор, өндөр хүчдэлээс болгоомжлох

13.7.Байгууллагын нийт ажилтнууд цэг салбарт байрлах галын хорны байршил,аваарын гарцын байршлыг хамгийн түрүүнд мэдсэн байх шаардлагатай.

13.8.Байгууллагын ажилтнууд ямар нэгэн эрсдэл учирсан бол нэн даруй удирдлага болон ХАБЭА-н ажилтанд мэдэгдэнэ.

Арван дөрөв. Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн, бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлсэн,дээрх аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон шаардлага биелүүлэхгүй тохиолдолд ажилтан, албан хаагч эрсдэлээ бүрэн хариуцна. Мөн ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Цахилгааны ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар зааварчилгаа

Нэг. Ерөнхий зүйл

Цахилгаан тоног төхөөрөмжийн болон цахилгааны засварчнаар тухайн мэргэжлээр суралцаж төгссөн мэргэжлийн үнэмлэхтэй 18-аас дээш насны хүмүүсийг ажиллуулна.

1.Цахилгаан тоног төхөөрөмжийн цахилгааны аюулгүйн нөхцөл дараах байдлаар ангилагддаг. Үүнд: (1000в хүртэл, 1000в-с дээш хүчдэлтэй)

2.Байгууллагын харъяаны 1000В-с доош хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, кабелийн шугам, толгой таслуур солиход заавал тусгай нарядаар ажил гүйцэтгэж ажиллана.

Байгууллагын харьяаны 1000В-оос дээш хүчдэлтэй бүх тоноглолд ажиллахдаа заавал нарядаар ажил гүйцэтгэж ажиллана.

4.Ажлыг гүйцэтгэхдээ цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, найдвартай ажиллагаа, хэвийн нөхцөлийг тооцож хийх хэрэгтэй.

5.Ажиллыг гүйцэтгэж байх үедээ зөвхөн ажилдаа анхаарлаа хандуулж аюулгүй байдлаа хангаж ажиллах шаардлагатай. Ажлын техник аюулгүй нөхцөл, бусад шаардлагыг хангасан эсэхийг шалгах хэрэгтэй.

6.Ажиллаж байгаа үедээ анхаарал болгоомжтой байхын зэрэгцээ өөрийн болон бусдын анхаарлыг сарниулах үйлдэл хийх, зөвшөөрөлгүй ажлын байраа орхих, өөр бусдын ажлыг дур мэдэн хийхийг хориглоно.

Хоёр. Ажлын байранд тавигдах шаардлага

1.Ажлын байрны аюулгүй нөхцөл бол чийг, цахилгаан гүйдэл дамжуулагчийн хүний амь насанд аюул учруулж болох аюултай хэсэг, галын аюул, дэлбэрэлт үүсэхээс хамгаалах явдал юм.

2.Ажлын байрны нөхцөлийг чийглэгээр нь хуурай биш, хэт чийглэг, хүчиллэг, онцгой хүчиллэг гэнэ.

3.Ажиллах газрын дулааны зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь +30с-аас ихгүй байна.

4.Ажлын байранд технологийн ажлын үндсэн дээр тоос/нунтаг/ их хэмжээгээр бий болж үүсдэг. Зарим тоос нь цахилгаан дамжуулах хүч болдог. Энэ нь хүний амь насанд маш аюултай зүйл юм. Иймээс аппарат хөдөлгүүрийн дотор талд тоос орохоос таш сайн хамгаалагдсан байх шаардлагатай.

5.Цахилгаан гүйдлийн аюултай нөхцөлийг ихэсгэж байгаа доорх зүйлүүдийг хатуу анхаарах хэрэгтэй. Үүнд :

1.Цахилгаан дамжуулагчдын цахилгаан орон үүсэхээс

2.Хэт өндөр температур бий болгохоос

3.Цахилгаан гүйдэл дамжуулдаг тоосонцор бий болгохоос

4.Хүмүүсийн аюулгүй ажиллагааг хангахын тулд цахилгаан тоног төхөөрөмжийн их биеэс/ корпус/ металлаар холбож газардуулга хийж өгдөг. Газардуулга хийсэн материалыг гадна талаар нь тусгаарлагч хийж өгнө.

5.Цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулга хийх зайлшгүй шаардлага:

6 Цахилгаан гүйдэл нь 500В ба түүнээс дээш хүчдэлтэй

7.Дэлбэрэх тэсрэх аюултай орчин байвал бүх төрлийн хүчдэлтэй үед газардуулга хийнэ.

8.Фазын юм уу нойл дамжуулагчийг газардуулга руу холбоно.

9.Тоног төхөөрөмжийн газардуулгыг цуваа холболтоор холбоно.

10.Газардуулгыг 5-25мм$^2$–аас багагүй голчтой уян цэс утсаар хийх хэрэгтэй. Мөн зөөврийн газардуулгыг дээрх материалаар хийх нь тохиромжтой. Зөөврийн газардуулгыг хийхдээ ил гарсан аль ч фазаас авч болно. Гэхдээ ажил явуулахад хялбар байх шаардлагатай. Дамжуулагчийн буюу газардуулсан утасныхаа төгсгөлийг газартай холбож өгсөн байх шаардлагатай.

11.Газардуулга, төхөөрөмжийн эсэргүүцлийн хэмжилт ба цахилгаан тоног төхөөрөмжийн дамжуулагчийг жилд нэгээс доошгүй удаа шалгаж үзсэн байх шаардлагатай.

12.Газардуулгын хамгаалах хэрэгслийн хэлхээний нийлбэр эсэргүүцэл 4 м-с ихгүй байна. Харин ерөнхий газардуулгын эсэргүүцэл 0,2-оос ихгүй байх шаардлагатай.

13.Газардуулгын дамжуулагчийг гагнуураар холбох бөгөөд зэв идэхээс хамгаалж /корроз/ хар өнгөөр будсан байх шаардлагатай.

14.Тусгаарлагчийн эсэргүүцлийг жилд нэг удаа, харин гэрэлтүүлгийн эсэргүүцлийг 3 жилд нэг удаа шалгаж үзнэ.

15.Цахилгааны ажилтнуудын хамгаалах нэг зүйл нь төхөөрөмжүүдийн цахилгаан хүчдэлээс хамгаалах хэрэгсэл юм.

16.Хамгаалах хэрэгслүүд нь тоног төхөөрөмжүүд, багаж хэрэгслүүд, аппаратуудыг цахилгаан хүчдэлээс/ цахилгаан орноос / хүмүүсийг хамгаалах юм.

17.Бүх тусгаарлагчаар хамгаалагдсан орчин нь дараах байдлаар ангилагдана. Үүнд:

1.Үндсэн хамгаалах багаж хэрэгсэл

2.Туслах хамгаалах багаж хэрэгсэл

3.Үндсэн хамгаалах багаж хэрэгсэл- тоног төхөөрөмжийн ажлын хүчдэлийг найдвартай барьж байх ба мөнх хүчдэлтэй , гүйдэл дамжуулагчийн зөвшөөрөгдөх хүчдэлээс илүү гаргахгүй барьж байх юм .

4.Туслах хамгаалах багаж хэрэгсэл -Тодорхой өгөгдсөн хүчдэлийн цахилгаан гүйдлийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор өөрөө хамгаалах нөхцөл юм. Туслах хамгаалах хэсэг нь үндсэн хамгаалах хэсэгтэй шууд холбоотой байдаг гутал, тусгаарлагдсан тавцан, байнгын болон зөөврийн газардуулга, сануулах плакат, нүдний шил, брезентэн бээлий зэрэг хамгаалах зүйлүүд орно.

Гурав. Ажлын байранд аюулгүй ажиллах заавар

1.Ажил гүйцэтгэхийн өмнө цахилгаанчин уг ажлыг гүйцэтгэх дараалал, аюулгүй ажиллагааны талаар тодорхой зааварчилгаатай танилцаж журналд гарын үсэг зурна.

2.Ажлын хувцсыг бүрэн өмсөж, шаардлагатай багаж хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэж ажил үүргээ гүйцэтгэнэ. Хамгаалах багаж хэрэгслийг урьдчилан уранхай, цоорхой, шороо тоосонд дарагдсан, найдвартай ажиллагаатай эсэхийг шалгаж үзэхгүйгээр ашиглахыг хориглоно.

3.Цахилгаан тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийхийн өмнө түүний техникийн паспорт дахь, зураг схем ашиглалтын зааввартай сайтар танилцсан байх хэрэгтэй.

4.Ажлын байрныхаа эд зүйлийг эмх цэгцтэй тавьж, ажиллах нөхцөлийг сайн хангасан байх

5.Засвар хийхдээ тоног төхөөрөмжийг хүчдэлээс заавал салгаж хүчдэлтэй эсэхийг дахин сайтар шалгасны дараа ажлаа гүйцэтгэнэ.

6.Ажил гүйцэтгэхийн өмнө тоног төхөөрөмжийн газардуулга бүрэн бүтэн байгаа эсэхийг заавал шалгасан байх хэрэгтэй.

7.Ажил гүйцэтгэж байхдаа газардуулсан металлыг гишгэх, гараараа барих зэргийг хатуу хориглоно.

8.Хүчдэлийг хэсэгчлэн тасалж хийхдээ цахилгаанчин хүчдэлийг таслах зайлшгүй шаардлагатай. Цахилгаан тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийхдээ хүчдэлээс салгаж удирдлагын щитний залгаж салгах автоматууд дээр “ЗАЛГАЖ БОЛОХГҮЙ ХҮМҮҮС АЖИЛЛАЖ БАЙНА” гэсэн анхааруулах тэмдэг өлгөсөн байна.

9.Зөөврийн гэрлийг 220в ба 36в-с дээш хүчдэлд залгаж болохгүй. Гэрэлтүүлгийн утсыг холбох үедээ найдвартай газардуулгыг хэрэглэвэл зохино. Онцгой аюултай байранд цахилгааны зааварчилга ёсоор 12в-оос дээш хүчдэлийг гэрэлтүүлгэнд хэрэглэж болохгүй.

10.Цахилгаан тусгаарлагч бээлийг 6 сард нэг удаа 2,5кв хүчдэл дамжуулах эсэхийг шалгаж үзсэн байх шаардлагатай. Цахилгаан тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийж дуусгаад хүчдэл өгөхийн өмнө зөв эсэхийг сайтар шалгаж залгалт хийх хэрэгтэй.

11.Цахилгаан тоног төхөөрөмжид үйлчилгээ хийх үед мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.

12.Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцан ажиллах хүмүүс нь шаардлагатай хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ. Хамгаалах хэрэгслийг хэрэглэхийн өмнө нарийвчлан шалгана. Ашиглаж буй багаж хэрэгсэл нь найдвартай ажиллагаатай, бүрэн бүтэн тусгаарлагчтай байх шаардлагатай.

13.Ажиллаж буй тоног төхөөрөмж дээр засвар үйлчилгээ тосолгоо хийхийг хориглоно.

14.Шит, унтраалга, автомат гэрэлтүүлгийн шит, залгуур, рубильник, цахилгаан дамжуулах кабель утас, хуурай салгуур, таслуур, хайрцаг, шкаф дээр хаяг заасан бичиглэл байх ёстой.

15.Хариуцсан хэсгийнхээ цахилгаан схем, тоног төхөөрөмжүүдийнхээ бүдүүвч зургийг мэддэг, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт ороход цаг тухайд нь тодотгол хийж чаддаг байх үүрэгтэй.

16.Галын багаж хэрэгсэл, галын хор байгааг шалгах,

17. Гэрлийн шилийг солихдоо унтраалгыг унтрааж, хамгаалах бээлийтэй ажиллах шаардлагатай.

18.Өндөрт байгаа гэрлийн шилийг солихдоо зөөврийн модон шат ашиглаж гүйцэтгэнэ. Төмөр шат ашиглахыг хориглоно.

19.Цахилгаан дамжуулах агаарын шугам болон кабелийн дор болон түүний ойролцоо зайд шугам хоолой, эд зүйлс бараа материал сэлбэг хэрэгсэл хураaж тавихыг хориглоно.

Цахилгаан багаж нь дараах шаардлагуудыг хангасан байх ёстой.

1.Цахилгаан сvлжээнээс тvргэн, амархан салгагддаг, залгагддаг байх.

3.Утас, кабелийг халуун, нойтон ба тостой гадаргуу болон биеттэй шууд шvргэлцэн хvргэж болохгvй.

4.Цахилгаан багаж ба зєєврийн цахилгаан машин ашиглаж байгаа хvмvvсд:

5.Түр хугацаагаар боловч тэдгээрийг бусад хүмүүст дамжуулан хэрэглүүлэх.

6.Тэдгээрийг задлаж єєрєє ямар нэгэн засвар хийхийг;

7.Цахилгаан багажны утаснаас барих, багажны эргэлдэн зvсэх хэсэгт хvрэх;

8.Машин бvрэн зогсохоос ємнє ажиллаж байх vед vрдэс зоргодосыг гараар зайлуулах

9.Тємєр тоног тєхєєрємж хадгалах сав зэргийн дотор зєєврийн трансформатор болон давтамж хувиргагчийг зєєж оруулах. Зєєврийн цахилгаан машин, багажийг цахилгаан сvлжээнд залгаатай нь болон хараа хяналтгvй орхих зэргийг тус тус хориглоно.

Дараах зүйлсийг хориглоно.

1.Тухайн ажлыг хийж гvйцэтгэх эрхгvй хvмvvс цахилгаан тоног тєхєєрємж дээр ямар нэгэн засварын ажил гvйцэтгэх.

2.Тусгаарлагдаагvй гvйдэл дамжуулах хэсэгт хvрэх

3.Хуваарилах самбар, удирдлагын самбар болон дэд єртєєний хаалгыг онгойлгох.

4.Гvйдэл дамжуулагч хэсгээс хашилт хамгаалалтыг авч зайлуулах.

5.Гагнуурын болон бусад цахилгаан утсан дээр гишгэх.

6.Цахилгаан техникийн бус хvн тоног төхөөрөмжийн цахилгаан залгуур, удирдлагын бие ангийн ажлын горимыг өөрчлөх болон тvvнд оролцох

7.Алхмын хvчдэлийн бvсэнд орвол уг бvснээс аль болохоор жижиг алхаж эсвэл нэг хєл дээрээ догонцон vсэрч гарах гэсэн зүйлийг анхаарахаас гадна бусад аюул эрсдэлийг тооцож ажиллана.

Дөрөв. Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн, бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлсэн, дээрх аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд ажилтан, албан хаагч эрсдэлээ бүрэн хариуцна. Мөн ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Мужааны ажлын аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаа
Нэг. Ерөнхий зүйл

Мужааны ажилтан нь 18 нас хүрсэн мэргэжлийн үнэмлэхтэй иргэнийг ажилуулна. Зохион байгуулалтын нэгжүүдийн ажлын байруудад гарсан модон эдлэлийн засвар үйлчилгээний ажлыг чанартай гүйцэтгэж, Монгол Улсад дагаж мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, эрх бүхий байгууллагаас гарсан дүрэм журам стандарт болон байгуулсан хөдөлмөрийн гэрээ дотоод дүрэм, журм ыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж осол авааргүй ажиллах үүрэгтэй.

Хоёр. Ажлын байранд аюулгүй ажиллах заавар

1.Ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэсэн байна.

2.Гар багажны иш нь 12%-иас илүүгүй чийглэгтэй хатуу төрлийн хус царс зэрэг модоор хийгдсэн, гадна тал нь сайтар засагдсан, багажиндаа бат бэх бэхлэгдсэн байна.

3.Цахилгаанаар сэргээгддэг гар багаж, хасуур, цоолтуур, цүүц зэргийг ажилд хэрэглэхдээ дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд :

- Ажлын хэсгийн ир үзүүр гэмтэлгүй байна
- Гараар барьдаг бариулын хажуу тал ирмэг хэсэг нь шамралтгүй байх
- Багажны бариулын урт нь тохирсон байх
- Сүх, цүүц, хасуур, гар харуулын ирүүдийг хамгаалсан хуйнд хийж байх

4.Механикжсан багаж төхөөрөмжөөр ажиллахдаа багажийг шалган гэмтэл илэрвэл засаж хэдийн ажиллагаанд оруулж байж ашиглана.

5.Суурь машин дээр мөд харуулдах зүсэх өрөмдөх, ховил гаргах ажил гүйцэтгэхдээ хаалт хамгаалалтыг бүрэн хийж газардуулгыг шалгаж, нүндний шил ханцуйвч хэрэглэнэ.

6.Суурь машин дээр мэргэжлийн бус, мужааны ажлын зохих мэдлэггүй хүнийг ажиллуулахыг хориглоно./ мэргэжлийн биш бол ажиллахгүй/

7.Мод зүсэх цахилгаан хөрөөг ажиллуулах үедээ хөрөөнд ан цав гарсан, ирэн эмтэрч хугарсан эсэхийг шалгаж байж ажиллуулна.

8.Зөөврлөж хэрэглэж буй багажийг залгах зориулалтын зөөврийн залгуурыг ашиглана.

9.Цахилгаан хөрөө харуул болон бусад цахилгаан хэрэгслээр ажил хийж эхлэхдээ бүрэн хүчэ авсан үед нь хөрөөдөх, харуулдах болон бусад үйлдлийг гүйцэтгэнэ.

10.Мөн ашиглахын өмнө удаан хугацаагаар ажилласны дараа хөрөөний ирний чанга сул эсэхийг байнга шалгана. Энэ үед хүчдэлийг салгасан байх шаардлагатай.

11.Таслах машин дээр ажиллах үед түүний ир нь хаалт хамгаалалттай байх, гэмьсэн ир хэрэглэхийг хориглох, ирийг тэр дор нь солих

12.Таслагчийн ирэнд ямар нэгэн ивээс хийх, шайб тавихыг хатуу хориглоно.

13.Модонд материалыг хөдөлгөөнгүй бэхэлсэний дараа зорж хөрөөдөх харуулдах тайрах зэрэг үйлдлийг хийж байвал зохино.

14.Ир үзүүртэй багажыг хол ойрын ямарч зайнаас хаяж шидэлгүй ишээр нь гардуулж өгнө.

15.Ажил дууссаны дараа суурь машин цахилгаан хөрөөг бүрэн унтрааж хүчдэлээс нь салгаж ажлын дараа цэвэрлэх шаардлагатай.

Гурав. Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн, бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлсэн,дээрх аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болон шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд ажилтан, албан хаагч эрсдэлээ бүрэн хариуцна. Мөн ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Жолоочийн ажлын аюулгүй ажиллагааны заавар зааварчилгаа

Нэг.Ерөнхий зүйл

Жолооч нь 18-аас дээш настай жолооны үнэмлэхтэй Монгол улсад дагаж мөрдөж байгаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Авто тээврийн тухай болон Замын хөдөлгөөгний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж түүнтэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журам, стандарт болон Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газартай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.Байгууллагын дотоод дүрэм журмыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж, болзошгүй аваар ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор жолооч нэг бүр доорхи аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөн ажиллана.

Хоёр Автомашинаар ажил гүйцэтгэх үеийн зааварчилгаа

1.Өдөр бүр ажилд гарахын өмнө автомашины техникийн бүрэн бүтэн байдал, техникийн хэвийн үйл ажиллагааг шалгах, эрүүл мэндийн хувьд хэвийн байх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, замын хуудас, жолоочийн үнэмлэхийг ажилд гарахдаа авч явах, ХАБ-н зааварчилгаа авч гарын үсэг зурах

2.Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдар шаардлага MNS4592-2003 улсын стандартыг бүрэн хангасан тээврийн хэрэгслээр ажил үйлчилгээнд гарах

3.Жолооч нь байгууллагын онцлогыг илэрхийлсэн лого бүхий хувцасыг өмсөж хэвшсэн байх

4.Автомашиндаа үзлэг үйлчилгээ хийхдээ бүх цахилгаан хэрэгслийг унтрааж аюулгүй байдлыг хангах, найдвартай ам нь сунаагүй түлхүүр багаж, домкрат ашиглах, домкрат ашиглах үед домкратны улнаас диаметрийн хувьд өргөн, даацын шаардлага хангасан байх давхар дугуйнд ивээс хийх шаардлагатай.

5.Машин дор орж ажиллах үед тоос шороо, төмрийн үртэс, химийн бодис, нүүр нүдэн дээр унаж гэмтэхээс болгоомжилж нүдний шил нүүрний хамгаалалт чихний бөглөөс заавал хийх, осол гэмтэл хурц хордлогоос сэргийлэх

6.Ажил үүрэг хүлээн авсан жолооч тухайн хэлтэс, албадын ажил хариуцсан ажилтаны өгсөн үүрэг даалгаврын дагуу өөрийн эзэмшиж буй техникийн хүчин чадлыг тооцон хийж гүйцэтгэнэ.

7.Налуу газар автомашин өнхрөхөөс сэргийлж дугуйнд ивүүрийг хийх

8.Байрнаас ухрах хөдөлгөөн хийх үед нүдээр шалгах, анхааруулах дохио өгөх зэргээр аюулгүй байдлыг хангах, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед бусдаас туслалцаа авах

9.Замын нөхцөл байдал хурдаа тохируулж /халтиргаа, гулгаа, нарийн гудамж, эгц өгсүүр, эгц уруу гэх мэт/ замын хөдөлгөөнд оролцож өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлч оруулахгүй байж аюулгүй зорчино.

10.Хөдөлгүүр унтраасны дараа автомашинаа шатахуунаар цэнэглэх

11.Эзэмшиж буй автомашинаа цэвэр үзэмжтэй байлгаж, өөрийн болон зорчигчийн ая тухтай байдлыг алдагдуулахгүй автомашинаас элдэв дуу чимээ, утаа бензиний үнэр гаргуулахгүй байх

12.Хөдөлгүүрийг асаахдаа хурдны хайрцагны арааг салгаж, зогсоолын тормосыг татсан үед гүйцэтгэх

13.Хөдөлгүүрээ унтраасны дараа буюу ажиж буулгах ажил гүйцэтгэх үед автомашины зогсоолын тормосын татаж 1 ба ухрах арааанд хурдны хайрцагийг залгана.

14.Автомашиныг гарааш талбайд тавихдаа тогтоосон журмын дагуу товлосон зай талбайд аюулгүй байдлыг хангаж тавих бөгөөд авто машиныг харуулд хүлээлгэн өгнө

15.Засвар үйлчилгээ хийж байх үед асгарсан түлш тосыг даруй цэвэрлэж зайлуулна.

16.Анхны тусламжийн цүнх, гал унтраагуур, ослын тэмдэгийг автомашиндаа тогтмол авч явах

17.Амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож удирдах ажилтануудад мэдээлэл өгөх

18.Жолооч нь ажлын онцлогтой холбогдуулан эрүүл мэндийн шинжилгээг жилд нэг удаа өгөх, өөрийн эрүүл мэндээ хамгаалж, эрүүл мэндийн үзлэгт сайн дураараа орох үүрэгтэй.

19.Жолооч нь дуудлагаар ажилд гараагүй зогссон өдрүүдэд эзэмшсэн тээврийн хэрэгсэлдээ техник үйлчилгээ засварын ажил болон албаны удирдлагаас өгсөн ажлыг хийж гүйцэтгэнэ

20.Тооцоог цаг хугацаанд нь тогтмол өгч, өмнөх замын хуудсаа өгч, дараагийн замын хуудсаа авч ажиллана

21.Зайлшгүй ажлын үед гар утсаа унтраахгүй байх, оршин суугаа хаяг өөрчлагдөж шинчлэгдсэн хаяг, утасны дугаараа тэмдэглүүлж байх

22.Зам тээврийн болон бусад болзошгүй осол тохиолдсон, ажил үүргээ цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон үед байгууллагын улирдлагад цаг алдалгүй мэдэгдэж байх

23.Жолооч нь тухайн тээврийн хэрэгслийг ашиглан ажил үүргээ гүйцэтгэсэн албан хэлтэсийн албан тушаалтнаар явсан км, хийж гүйцэтгэсэн ажлын талаар бичилт хийлгэн гарын үсэг зуруулна



24.Жолооч нар орой ажлаас буухдаа тээврийн хэрэгслийг гражид байрлуулан түлхүүрийг үүдний харуулд үлдээнэ.

25.Цаг бүртгэлийн системд бүртгүүлж ажил эхлэх ба ажлаас бууна.

26.Ажилтан ажил гүйцэтгэхдээ заавал хэрэглэх зүйлийг сануулсан тэмдэг

27.Ажил гүйцэтгэж байгаа нэгнийхээ анхаарлыг сарниулан тоглож наадахгүй байх



28.Гараар ачаа өргөхдөө биеийн байрлалыг зөв байрлуулж өргөх, буруу байрлалтай өргөснөөр нуруу нугас гар хөлөө гэмтээх аюултай

29.Халтирч унах - Бүдэрч унах - Усанд унах -Гар цохих, хавчуулах -Хөлөө цохих хавчуулах -

30.Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж явах – Толгойгоо цохих - Эргэлдэх механизмд гар хөлөө хавчуулах - Автомашины хөдөлгөөнөөс болгоомжлох - Аккумляторын шингэнээс болгоомж ажиллана.

Суудлын автомшинд тавигдах техникийн нэмэгдэл шаардлага mns 4592-2003

1.Хэрэглэх хүрээ. Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцох бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлагыг тогтооно.

2.Зорилго. Авто тээврийн хэрэгслийн ашиглалтын сөрөг үр дагавруудыг багасгаж хязгаарлах, хэмнэлт, экологи, хөдөлгөөний аюулгүйн үнэлгээг дээшлүүлэх, энэ талаарх тавих төрийн хяналтыг хүчтэй болгох зорилготой. Мөн энэ стандартын шаардлагыг бүрэн хангасан автотээврийн хэрэгсэлд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрөл олгоно.

Гурав. Нийтлэг шаардлага.

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр автозамын хөдөлгөөнд оролцох бүх төрлийн тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийг бүрэн хангасан байна

3.2.Автотээврийн хэрэгсэл нь төрөл бүрийн ачаа, зорчигч тээвэрлэх нөхцөл, автотээврийн хэрэгсэол тавих нийтлэг болон улс ба хот хоорондын харилцаанд ачаа, зорчигч, жуулчин тээвэрлэх,тэрчлэн нийтийн тээврийн автобус, таксинд тавих нэгдмэл шаардлагуудыг бүрэн хангасан байна.

3.3.Эдэлгээний баталгаат гүйлт, гүйлтийн нөөц ихтэй, техникийн үйлчилгээ , засвар бага шаардах, найдварт ажиллагааны түвшиг өндөр байна.

3.4.Техникийн хувьд шинэлэг, хийц загвар өнгө үзэмж сайн, хэмнэлттэй шатахуун, тосолгооны материал, ашиглалтын бусад материал бага зарцуулдаг байвал зохино.

3.5.Замын хөдөлгөөнд оролцох авто тээврийн хэрэгсэл нь техникийн хувьд бүрэн бүтэн, техникийн үйлчилгээ, тохиргоог бүрэн хангасан, техникийн хяналтын улсын үзлэг, тооллогод хамрагдаж тэнцсэн, замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийн гэрчилгээ авсан байна.

3.6.Автотээврийн хэрэгслийн улсын дугаар, таних болон ялгах тэмдэг, бичлэгүүд батлагдсан стандарт, техникийн шаардлагын дагуу бүрэн, үзэмж чанартай хийгдэж тавигдсан байна.

3.7.Автотээврийн хэрэгслийн тэвш, бүхээг, чингэлэг, гишгүүр, шат бариул, суудал, түшлэг нь тээвэрлэлтийн нөхцөл, стандартын шаардлагыг хангасан байна.

Суудлын автомашинд тавих техникийн нэмэгдэл шаардлага

Суудлын автомашины кузов-Суудлын автомашины кузов нь өнгө үзэмж, битүүмжлэл сайн, ялангуяа гадны орчноос тоос шороо, дуу чимээ, ус нэвтрэхгүй байвал сайн. Салхины болон хажуугийн, арын шилнүүд, шал, хаалга, капот, тээшний түгжээ бүрэн, эвдрэл гэмтэлгүй байна. Суудал, түшлэг нь тавлаг зөөлөн, жолоочийн биеийн жин, өндрөөс хамааруулж тохируулах боломжтой, жолооч зорчигчдын бие хөлрөх, чийг татах явдал гаргахгүй тусгай материалаар бүрсэн байна.

Урд ба арын суудалдаа үйлдвэрлэгчээс тавьсан аюулгүй бүс зайлшгүй байна.

Жолооны механизм -Жолооны хүрдны сул эргэлт нь 10 градусаас илүүгүй, эргүүлэхэд зөөлөн байна. Жолооны хүрдны зөвшөөрөгдөх сул эргэлт нь жолооны механизмын бүрдэл хэсгүүдэд жигд хувиалагдсан байна.

Тоормосны систем- ажлын болон зогсоолны тормосны ажиллагаа нь найдвартай, хөдөлгөөний удаашралыг хамгийн доод хэмжээ 5.8м/сек$^2$ байна. Хөдөлгөөний удаашралт 8м/сек$^2$ хүртэл явагдах үед урд дугуйнууд хойд дугуйнуудаас урьтаж тоормослоно. Зогсоолын тоормос нь 23.0% налууд уг автомашиныг хөдөлгөөнгүй барьж байх шаардлагатай.

Явах анги- дугуйн хийн даралтын байвал зохих хэмжээг үйлдвэрлэгч тухайн авто машины хийц загвар, бүтцээс хамааруулан тодорхойлно. Дугуйн хээний гүн нь газарт ьулах хэсгээрээ 1.6 мм-ээс багагүй байх бөгөөд дугуйны элэгдлийн тэмдэглэгээний хязгаар хүрсэн тохиолдолд ашиглахыг хориглоно.

Цахилгаан тоноглол- гэрэлтүүлэг дохиоллын хэрэгслүүдээр, тухайлбал гэрлийн шил, чийдэн, ойлгогч гэх мэт иж бүрэн тоноглогдсон, тэдгээр нь олон улсын шаардлага хангасан байна. Урд гэрлийн тохиргоо алдаагүй хэвийн байна. Хурд хэмжүүр нь баталгаажуулагдсанбайх бөгөөд дуут дохио бүрэн ажиллагаатай байна.

Гэрлийн өнгө – урд гэрэл: цагаан

1.Манангийн гэрэл: шар

2.Хойд гэрэл: улаан

3.Хажуугийн гэрэл-шар

4.Зогсоолын гэрэл-улаан

5.Дохионы гэрэл- улбар шар
6.Ухрах хөдөлгөөний гэрэл-цагаан

Бусад нэмэгпэл төхөөрөмжүүд-жолоочийн ажиллах, зорчигчдийн аятай тавлаг зорчих нөхцөлийг бүрэн хангахын тулд дараах нэмэгдэл хэрэгсэл, төхөөрөмжүүдээр тоноглогдсон байх шаардлагатай. Үүнд:

- Нарны хаалт
- Гал унтраагуур
- Жолоочийн иж бүрэн багаж хэрэгсэл
- Автомашины өргүүр
- Нөөц дугуй
- Дугуйн ивүүр 2ш
- Эмийн сан
- Ослын зогсолтын тэмдэг
-

Гурав. Жолоочийн хориглох зүйлс

1.Автомашин жолоодох эрхийн үнэмлэх тээврийн хэрэгслийн гэрчилгээний аль нэг нь байхгүй тохиолдолд автомашин жолоодохыг хориглоно.

2.Техникийн бүрэн бүтэн байдлыг хангаагү, х өдөлгөөний аюулгүй байдалд аюул учруулахуйц бүрэн бус техникээр ажил үйлчилгээнд гарахыг хориглоно.

3.Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн,биеийн эрүүл мэндийгб айдал муу, хэт ядарсан үед автомашин жолоодохыг хориглоно.

4.Тухайн төрлийн автомашинаас тогтоосон нормоос олон хүн тээвэрлэхийг хориглоно.

5.Автомашины зогсоол талбай, граш ил гал гарах түлштэй сав, тостой алчуур даавууг хадгалах, тэжээлийн системийн ойролцоо тамхи татах, согтууруулах ундааны зүйл хэрэгдэх, мөрийтэй тоглох, чанга ярьж бусдын анхаарлыг сарниулахыг хориоглоно.
Бусдад жолоог дур мэдэн шилжүүлэхийг хориглоно.

1.Автомашины хөдөлгүүр ажиллаж байх үед кабиндаа амрах унтах, хөдөлгүүрийг битүү хучиж асаах, доор нь гал түлэхийг хориглоно

2.Автомашины резин дугуйнууд нь стандартад тохирсон байх ба урд тэнхлэгт стандартын шаардлага хангахгүй тэнхлэг таьихыг хориглоно.

3.Жолооч нь баталгаат замаас бусад замаар зорчихыг хориглоно.

4.Шатахууныг хувин буюу задгай саваар зөөж хийхийш хориглоно.

5.Тээврийн хэрэгслийн бүхээгт гадны хүн зөвшөөрөлгүйгээр суулгаж оруулж ирэх, засвар үйлчилгээ хийлгэхийг хориглоно.

6.Гудамж замын хөдөлгөөнд оролцож байхдаа Замын хөдөлгөөний хуулийн заалт нэг бүрийг чанд сахин, бусадтай хэрэлдэх, маргах, уурлах зэрэг гаж буруу зан ааш гаргах

7.Удирдлагын зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

8.Замын хуудсанд олгохоор бичигдсэн шатахууны төрөл, маркаас зөрүүлж өөр төрөл, маркын шатахууныг түгээх станцаас авах

9.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил таслах, ажлын цагаас хоцрох, эрт явах

Дөрөв. Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн, бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлсэн, дээрх аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болон шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд ажилтан, албан хаагч эрсдэлээ бүрэн хариуцна. Мөн ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## Үйлчлэгчдийн ажлын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

### Нэг. Ерөнхий шаардлага

1.Үйлчилгээний ажилчид нь 18-аас дээш насны цэвэрч нямбай харилцааны соёлтой иргэн байна.Байгууллагын нэгжүүдийн ажлын байрыг хуваарийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг чанартай гүйцэтгэж, Монгол Улсад дагаж мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, эрх бүхий байгууллагаас гарсан дүрэм журам стандарт болон байгуулсан хөдөлмөрийн гэрээ дотоод дүрэм, журмыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж осол авааргүй ажиллах үүрэгтэй. 2.Үйлчилгээний ажилчдад аюултай болон хортой хүчин зүйлүүд нөлөөлж болно. Үүнд - Цэвэрлэгээний орчинд хагарсан шил, зүү хатгуур байх, юманд цохиулах даруулах

2.Үйлчилгээний ажилчдад аюултай болон хортой хүчин зүйлүүд нөлөөлж болно. Үүнд - Цэвэрлэгээний орчинд хагарсан шил, зүү хатгуур байх, юманд цохиулах даруулах

-Шил толийг цэвэрлэж байх үед бэхэлгээ муудсанаас хагарч унах

-Цахилгааны залгуур монтажны утас ил байснаас нойтон зүйлтэй хүрэлцэж хүчдэлд цохиулах

-Чулуун шал /ялангуяа өвлийн улиралд / цэвэрлэх явцад мөстөж хальтаргаа үүсэх

-Зориулалтын бус химийн бодисоор дур мэдэн цэвэрлэгээ хийснээс хордох

-Хаалга болон бусад зүйл мөргөх, нойтон шалан дээр халтирах зэргээс болгоомжлон аюул эрсдэлийг тооцох чадвартай байх ёстой.

3.Үйлчлэгч нь ажил гүйцэтгэж байхад биед нь ямар нэгэн зовиур илрэх, гэнэтийн осол гарах, ажиллагсадын болон өөрийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох аливаа нэгэн зөрчил илэрвэл тухай бүр хариуцсан ажилтанд яаралтай мэдэгдэж зөрчил арилсаны дараа үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэн гүйцэтгэх ёстой.

### Хоёр. Ажлын байран дахь аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1.Үйлчлэгч та ажилд орохдоо ажлын дүрэмт хувцсыг биедээ тохируулан цэвэр үзэмжтэй өмссөн байна.

2.Ажил эхлэхийн өмнө ажлын багаж хэрэгсэл бүрэн эсэхийг шалгаж дутуу бол гүйцээж ажилаа эхэлэх.

3.Ажил үүргээ гүйцэтгэж байхдаа халтирч унах бүдэрч унах, өрөө тасалгааны хаалганд гар хөлөө хавчуулах, толгойгоо цохих, хагархай болон үзүүртэй, хурц иртэй зүйлд гараа зүсэх, хатгах аюул эрсдэлээс сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах

4.Ажил үүргээ гүйцэтгэж байхдаа алба хаагчид болон үйлчилүүлэгч иргэдтэй зөв боловсон харилцах

5.Ажилтнуудын өрөө тасалгааг цэвэрлэж байхдаа компютерт хийж байгаа зүйлээ хадгалаарай гэсэн шаардлага тавьж цэвэрлэх

6.Нойтон чийгтэй гараар цэвэрлэгээ хийж байхдаа цахилгаан хэрэгслийн тогонд цохиулах аюул тулгарч болох тул анхаарал болгоомжтой ажиллана.

7.Цонх, тавцан өндөр нөхцөлд цэвэрлэгээ хийж байхдаа унаж бэртэх аюул эрсдэлээс сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах, шаардлагатай тохиолдолд албаны даргад мэдээлэх тусламж авах.

8.Өрөө тасалгаа цэвэрлэгээ, коридорт цэвэрлэгээ хийж байхдаа эд хогшил, эд зүйлийг хөдөлгөж цэвэрлэсэн бол эргэж байранд нь тавьж байх

9.Бусдын эд зүйдийг дур мэдэн авахгүй байх

10.Плита гадагуу бүхий шал, шат цэвэрлэж байхдаа өөрөө халтирч унах болон бусад хүмүүс хальтарч унах эрсдэл унах эрсдэл үүсэж болохыг анхааруулж ажиллах

11.Цэвэрлэгээ үйлчилгээг хувийн дагуу тогтмол хугацаандаа чанартай сайн цэвэрлэж ажиллах

12.Өрөө тасалгаа цэвэрлэж байхдаа цахилгааны утас болон телефон утсанд тээгэлдэж унаж, гэмтэж бэртэхээс сэргийлж ажиллах

13.Өрөө тасалгаа нойл коридороос гарсан хог хаягдлыг зориулалтын хогын саванд хийж хаях

14.Өндөр нөхцөлд цэвэрлэгээ хийхдээ тулгуур суурь сайтай тавцан бүхий шатан дээр зогсож цэвэрлэх

15.Ажилд ашиглаж буй багаж хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангаж зөв аюулгүй ажиллагааг хангаж ажиллах чадвартай байх.

16.Өөрийн ажилчдын байранд эмх цэгцтэй, цэвэрхэн байх ажлын шаардлагагүй хүмүүсийг оруулахгүй байх

17.Ажлын цагаар чөлөө зөвшөөрөлгүй ажлын байраа орхиж явахгүй байх.

18.Ажлын байранд согтуурах мансууруулах зүйл хэрэглэхгүй байх

19.Ажил дууссаны дараа багаж хэрэгслээ цэвэрлэж, эмх цэгцтэй байршуулж байгууллагын дотоод журмын дагуу цагийн бүргтгэлд бүртгүүлэх.

20.Цэвэрлэгээний бодистой зөв зохистой стандартын дагуу хэрэглэх дадалтай байх

21.Цэвэрлэгээ хийх явцдаа резинэн бээлийг зориулалтын дагуу хэрэглэх.

Дөрөв. Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн, бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлсэн, дээрх аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болон шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд ажилтан, албан хаагч эрсдэлээ бүрэн хариуцна. Мөн ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Няравын ажлын байр зааварчилгаа

Нэг. Ерөнхий шаардлага

1.Няравын ажилтнаар нь 18-аас дээш санхүүгийн анхан шатны мэдлэгтэй мэдээ тайлан гаргах чадвартай цэвэрч нямбай харилцааны соёлтой иргэн байна. Монгол Улсад дагаж мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, эрх бүхий байгууллагаас гарсан дүрэм журам стандарт болон байгуулсан хөдөлмөрийн гэрээ дотоод дүрэм, журмыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж осол авааргүй ажиллах үүрэгтэй.

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, технологийн горимыг мөрдөж ажиллана.

3.Ар гэртээ сайтар амарч согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөөнөөс ангид ажилдаа ирнэ.

4. Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж, дэвтэрт тэмдэглэнэ.

5. Гадуур хувцсыг зориулалтын шүүгээ, өлгүүрт хийж, ажлын тусгай хувцсыг бүрэн хэрэглэнэ.

6.Ажлын байрны лац ломбо болон цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг шалгана. Гэмтэл, үл тохирол илэрвэл холбогдох ажилтанд мэдэгдэж, засч арилгасны дараа ажил үүргээ эхэлнэ.

7.Нярав нь ажил үүргийн хуваарьт тусгагдсан буюу ажил удирдагчийн заасан ажлыг гүйцэтгэхтэй холбогдсонаюулгүйажиллагааны зааварчилгаатай танилцаж, дэвтэрт гарын үсгээ зурна.

Хоёр. Ажлын байран дахь аюулгүйажиллагааны зааварчилгаа

1.Агуулах нь байнга эмх цэгцтэй. цэвэрхэн байх бөгөөд гадны хүн орж болохгүй.

2.Агуулахын байр нь хангалттай гэрэлтүүлдэг, гадна талдаа хамгаалалттай гэрэлтүүлэгтэй байна. Гэрлийн монтаж нь далд, цахилгааны утасны диаметр нь ачаалал даахуйц байна.

3.Агуулахын гэрлийн унтраалга, залгуурууд нь технологийн дагуу хийгдсэн, контакт нь найдвартай, сул биш байх хэрэгтэй.

4. Агуулахын тавиурууд нь бат бөх хийгдсэн байна.

5.Агуулахад хэрэглэх зөөврийн шат нь бат бөх, хөдөлгөөнгүй, дээд талын тавиурт байгаа бараа, эд зүйлийг авахад хүрэлцэхүйц өндөртэй байх хэрэгтэй.

6.Тавиур, тавцан руу бүү авир. Дээд талын тавиурт хүрэхийн тулд шат, тавцан, гишгүүрашигла.

7.Сэлбэг хэрэгсэл, эд хогшлыг хураахдаа нурж унахааргүй, цөөн тоогоор давхарлажтавина.

8.Турбо, лааз, торх зэрэг өнхрөх зүйлсийн наагуур хаалт хийх буюу бэхэлсэн байна.

9.Жижиг, хүнд зүйлсийг дээд тавиурт нүдэнд харагдахуйц тавина.

10.Химийн бодисыг хадгалахдаа зохих агааржуулалт, температурыг хангах болон бусад хамгаалах арга хэмжээг авсан байна. Зарим бодисуудыг хамтад нь хадгалж болдоггүйг сана.

11.Бараа материалыг хөлд тээглэхгүй, тавиураас илүү гарган хурааж болохгүй. Тавиур дээр тавьсан эд зүйлсийн хаяг, нэр, тоо ширхгийг нүдэнд ил харагдахуйцаар бичиж тавьсан байна.

12.Шатах, тослох, тэсэрч дэлбэрэх материалыг тусгай зориулалтын байранд хадгална. Шатах, тослох, тэсэрч дэлбэрэх материалын агуулахын гадна, дотор талд анхааруулах санамжийг байрлуулах шаардлагатай Агуулахад галын дохиолол байх шаардлагатай.

13.Онцгой байдлын үед агуулахаас түргэн гарах боломжтой байна. Тавиур хоорондын зай, эгнээ зэргийг бүү битүүлж мухарла.

14.Агуулах дотор болон агуулах орчимд гал унтраах төхөөрөмж заавал тавьсан

15.Ажлын хувцас, бээлий, ариун цэврийн хэрэгслийг хувцасны шүүгээнд хийж хадгалах бөгөөд бусад зүйлсийг хадгалахыг хориглоно

16.Ажлын хувцастайгаа цайны газарт орох, гудамж талбайд явах, гэртээ авч явахыг хориглоно.

17.Ажлын хувцсыг тогтоосон хугацаанд цэвэрлүүлж байх бөгөөд хэт бохир хувцас, хэрэгсэл өмсөхийг хориглоно.

18.Ажилдаа ирж очихдоо аюулгүй, баталгаажуулсан маршрутыг сонгон, аюулгүй байдлаа хანган зорчино.

19.Агуулах доторх галын хор, галын хоолой, бусад төхөөрөмжийг халхалсан байдлаар барааг бүү хураа.

20.Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

21.Агуулахын агааржуулагч, салхивч, халаагуур зэргийг шалгаж цахилгаан хэрэгслүүдийг тэжээлээс салгана.

22.Агуулахын хаалгыг лацдан, жижүүрт хүлээлгэн өгнө.

Гурав.Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн, бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлсэн,дээрх аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болон шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд ажилтан, албан хаагч эрсдэлээ бүрэн хариуцна. Мөн ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Сантехникч, слесарийн ажилчидад мөрдөх аюулгүй ажиллагааны заавар

Нэг. Ерөнхий шаардлага

Сантехникч, слесарийн ажилтан нь 18 нас хүрсэн мэргэжлийн үнэмлэхтэй иргэнийг ажилуулна. Зохион байгуулалтын нэгжүүдийн ажлын байруудад гарсан засвар үйлчилгээний ажлыг чанартай гүйцэтгэж, Монгол Улсад дагаж мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, эрх бүхий байгууллагаас гарсан дүрэм журам стандарт болон байгуулсан хөдөлмөрийн гэрээ дотоод дүрэм, журм ыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж осол авааргүй ажиллах үүрэгтэй.

1.1.Сантехникийн чиг үүрэгт холбогдох ажил үүргийг гүйцэтгэх даалгавар авсан ажилтан Та энэхүү "Сантехникийн слесарийн мөрдөх аюулгүй ажиллагааны заавар №31. НКХАБ–УС–3.031"–ын заалт нэг бүртэй сайтар хичээнгүйлэн танилцаж, зөв хэрэгжүүлэх нь таны гарт байна.

1.2.Сантехникийн чиг үүрэгт холбогдох ажил үүрэг гүйцэтгэгчид нь 18 насанд хүрсэн, эрүүл мэндийн үзлэгт орж тэнцсэн, тусгай мэргэжлийн сургууль, курсийг төгсөж энэ чиглэлээр ажиллах эрх, мэргэжлийн үнэмлэх, сертификат авсан, нийт ажиллагсадын ХАБЭА–н нийтлэг заавар, галын аюулгүй ажиллагааны заавар, анхны тусламжийн заавар, энэхүү зааврaар зааварчилгаа авсан байна.

1.3.Зөвхөн ажлын даалгаврын дэвтэрт тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.4.Шинэ тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хэрэглэх шаардлагатай болсон үед тэдгээр төхөөрөмжийн бүтэц, зохион байгуулалт, ажиллагааны талаар заавал мэдэж ХАБЭА–н давтан зааварчилгаа авбал зохино.

Хоёр. Ажлын байрны зааварчилгаа

2.1. Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ХАБЭА–н талаар хүлээсэн үүргээ сайтар мэдэж, зайлшгүй биелүүлнэ.

2.2.Зөвхөн мастерын даалгасан ажлыг гүйцэтгэнэ.

2.3.Техникийн ашиглалтын дүрэм, замын хөдөлгөөний дүрэм, барилгын талбайгаар зорчих журам, галын аюулгүйн дүрмийг мөрдөж ажиллана.

2.4.Ажлын байр, түүний хаалганы ойр орчимд элдэв материал, эд анги, хог хаягдлыг хөглөрүүлэлгүй ажлын байрны эмх цэгц, цэвэр байдлыг эрхэмлэнэ.

2.5.Ажлын байрны ойр орчим, орох, гарах газруудын шалан дээр аливаа шингэн зүйлийг үл асгана. Ус, тос, шингэн асгарсан байгааг Та харсан бөгөөд эсвэл Та өөрөө тэдгээрийг асгасан бол элс, модны үртэс цацаж элдэв арчих зүйлээр шалыг хаттал арчиж цэвэрлээд, дахин асгарах, гоожихгүй байлгах арга хэмжээг заавал авна.

2.6.Зөвхөн бүрэн, бүтэн, аливаа гэмтэлгүй, шалгагдаж, туршигдан зохих эрх бүхий албан тушаалтны бичгээр өгсөн ажиллуулах зөвшөөрөл бүхий тоног төхөөрөмжөөр ажил гүйцэтгэнэ.

2.7.Ачаа өргөж, буулгах үед заавал дуулга малгай өмсөнө.

2.8.Тоостой орчинд ажиллах үед амны баг заавал хэрэглэнэ.

2.9.Залгуур, гал хамгаалагчийн бүрхүүлийн бүрэн, бүтэн байдлыг заавал шалгана.

2.10.Ажлын байрны гэрэлтүүлэг хангалттай эсэхийг заавал шалгана.

2.11.Аливаа цахилгаан аппарат, тоног төхөөрөмжүүдийн газардуулга, агааржуулах системийн бүрэн, бүтэн байдал, найдвартай ажиллагааг сайтар шалгасны дараа ТА зөвхөн ажлын даалгаварт тусгагдсан ажлыг гүйцэтгэнэ.

2.12.Тоног төхөөрөмжүүдэд аливаа эвдрэл, гэмтэл илэрвэл энэ тухай нэн даруй мастерт мэдэгдэж зохих арга хэмжээг авахуулж, тоног төхөөрөмжийн ажиллагааг туршсаны дараа ажлаа эхэлнэ.

2.13.Ажлын байранд гадны хүн оруулж, байлгаж үл болно.

2.14.Өндөрт ажиллах тохиолдолд хашлага, хамгаалалтууд (шат, тавцан, хөндлөвч)–ыг заавал хэрэглэж тэдгээрийг хөдөлгөөнгүй, бат бэх суурилсан эсэх, түүнчлэн ажиллах газар руу дамжиж очиход тохиромжтой, аюулгүй, найдвартай эсэхийг тус тус шалгана. Хөлтэй тавцан, хөндлөвч тавцангуудын техникийн тодорхойлолт, даацыг заавал мэддэг байна.

2.15.Агаар оруулах, гаргах салхивчны ажиллагаа найдвартай эсэхийг шалгана.

2.16.Ажил эхлэхийн өмнө ажлын даалгаврыг бичгээр авч, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна.

2.17.Ажлын байранд ирээд дараах дүрмийг заавал мөрдөнө. Үүнд:

2.17.1.Ажлын байр, хамгаалах багаж хэрэгслийн бүрэн, бүтэн байдлыг шалгана;

2.17.2.Ажлын багаж хэрэгсэл, механизмын бэлэн байдал, гэрэлтүүлэг хангалттай эсэхийг шалгана;

2.17.3.ХАБЭА–н зөрчил илэрвэл зөрчлийг яаралтай арилгах, хэрэв өөрөө арилгаж чадахааргүй тохиолдолд ажлаа гүйцэтгэлгүйгээр хэсгийн даргадаа мэдэгдэнэ;

2.17.4.Бүрэн зогсоогүй механизм, ус зайлуулах байгууламжийн салгагдаагүй хэсэг дээр ажил гүйцэтгэж болохгүй;

2.17.5.Ус зайлуулах байгууламж, худгийн таг хаалттай эсэхийг хянаж байна;

2.17.6. Ажлын байрны орц, гарцыг элдэв хог, хаягдалгүй, чөлөөтэй байлгана.

2.18.Зөвшөөрөл–нарядаар гүйцэтгэгдэх онц аюултай ажлын жагсаалт, ХАБЭА, экологи, байгаль орчны аюулгүй ажиллагааны ноцтой зөрчилд тооцогдох ажлуудын жагсаалтыг мэддэг байна.

2.19.Тухайн ажлыг гүйцэтгэхийн өмнө ХАБЭА–н зааварчилгаа авч зөвшөөрөл–наряданд гарын үсэг зурж, шаардлагатай багаж хэрэгслийг авах, нарядад бичигдсэний дагуу аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг авч ажлын байрыг бэлэн болгоно.

## Гурав. Ажлын гутал хувцас хамгаалах хэрэгсэл

3.1.Ажил гүйцэтгэхдээ улирлын байдалд тохирсон зориулалтын хувцас, гутал өмсөж гүйцэтгэх ажлын онцлогт тохируулан бүрэн, бүтэн хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.

3.2.Зөвхөн нормын дагуу шаардлага хангасан ажлын тусгай хувцастай ажиллана. Хөнгөн гутал (сандааль, гэрийн шаахай, спортын пүүз, кеды г.м) өмсөхийг хатуу хориглоно.

3.3.Ажлын хувцас, гутал, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу зөв хэрэглэнэ.

3.4.Бохирдсон ажлын хувцсыг цаг тухайд нь цэвэрлэгээнд өгнө.

3.5.Өөрт нормын дагуу олгосон ажлын хувцас, гутал, хамгаалах хэрэгслийн бүрэн, бүтэн байдлыг үргэлж анхаарч ажиллана.

3.6.Өөрт таараагүй томдсон, жижигдсэн, урагдсан, салбарсан, унжсан, санжсан хувцас өмсөж үл болно.

3.7.2м–ээс дээш өндөрт ажил гүйцэтгэхдээ бүрэн бүтэн, туршилт хийгдсэн хамгаалах бүсийг хэрэглэх ба түүнийг ажлын даалгаварт заасан найдвартай тулгуураас бэхэлнэ.

3.8.Толгой хамгаалах дуулга малгайг байнга өмсөж ажил гүйцэтгэх ба дуулга малгайг толгойноос унахаас сэргийлж бүчийг сайтар бэхэлнэ.

3.9.Тусгай зассан талбай байхгүй нөхцөлд өндөрт гарч ажил гүйцэтгэх үедээ доош унахаас сэргийлж хамгаалах бүс хэрэглэнэ.

3.10.Худагт орж ажил гүйцэтгэх үед амьсгалын эрхтнийг хамгаалах хийн баг хэрэглэнэ.

3.11.Хамгаалах хэрэгслүүдийг хэрэглэхийн өмнө тэдгээрийн бүрэн, бүтэн байдлыг гадна үзлэгээр шалгахын зэрэгцээ туршилтын хугацааг заасан пайзаар нь шалгана.

- Хамгаалах бүс, олс 6 сард 1 удаа
- Зөөврийн модон шат 1 жилд 1 удаа

3.12.Засварласан, холбож залгасан аврах олс, мөн олсыг кабель, дамжуулагч утас, төмөр утас, бусад зүйлээр орлуулж ашиглахыг хориглоно.

Дөрөв. Аюул, осол, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх

4.1.Зам, талбайгаар явахдаа явган хүний замаар явах ба хэрэв байхгүй бол авто замын зүүн талыг барьж явна.

4.2.Бүрэн бус багажаар ажил гүйцэтгэж үл болно. Алх, лантууны иш нь цуурч цав гараагүй, гөлгөр гадаргуутай байна. Хуурай, хутга, отвертка нь бариулдаа найдвартай бэхлэгдсэн байна. Эдгээр багажийг бариулгүйгээр ашиглаж үл болно.

4.3.Хориглох зүйлс:

4.3.1.Тухайн ажлыг гүйцэтгэхэд суралцаагүй хүнээр ажил гүйцэтгүүлэх;

4.3.2.Хамгаалах шил зүүлгүйгээр төмөр, металлыг огтлох;

4.3.3.Даралттай хоолойг засварлах;

4.3.4.Хамгаалах бүс зүүлгүйгээр өндөрт ажиллах;

4.3.5.Туршилтын хугацаа нь дууссан, гэмтэлтэй хамгаалах хэрэгслийг ашиглах;

4.3.6 Бичгээр авсан зөвшөөрөлгүйгээр галын ба тэсрэх аюултай газарт галын аюултай ажил гүйцэтгэх;

4.3.7. Шал, тавцангаас 2м–ээс дээш өндөрт хамгаалах хэрэгсэлгүйгээр ажиллах.

4.4.Бичгээр авсан зөвшөөрөл–нарядгүйгээр дараах ажлуудыг гүйцэтгэхийг хориглоно. Үүнд:

4.4.1. Цахилгааны хүчний кабель, ус, уур дамжуулах шугам, дулааны шугам байрласан хэсэгт газар шорооны ажил гүйцэтгэх;

4.4.2. Газар доор ба худагт орж хийж гүйцэтгэх ажлууд, тухайлбал камер, суваг доторх хоолойг засварлах, сүлжээнд гарсан ваарыг устгах.

4.5.Худаг дотор ганцаар ажил гүйцэтгэхийг хориглоно. Газар дээр худгийн ойролцоо хоёр дахь хүн байж ажлын аюулгүй байдлыг хянана.

4.6.Худаг дотор ажил гүйцэтгэж эхлэхийн өмнө шлангтай хийн багийг сайтар шалгасны дараа шлангтай хийн багийг өмсч худаг руу бууна. Шлангын төгсгөл худгийн гадна цэвэр агаар өгөх боломжтойгоор байрласан байна.

4.7.Худаг руу орохын өмнө хамгаалах бүс зүүж, бүсэндээ аврах олсыг бэхлэх ба олсны сул үзүүр худгийн гадна үлдэх 2 дахь ажилчны гарт байна.

4.8.Вентиль, хаалтыг зориулалтын бус багажаар онгойлгох, түлхүүрэнд хоолой, бусад зүйлс залгаж ашиглахыг хориглоно.

4.9.Галын аюулгүй байдлын дараах арга хэмжээнүүдийг мөрдөж ажиллана. Үүнд:

4.9.1.Зөвхөн тусгай зориулалтын газарт тамхи татна;

4.9.2.Амархан шатдаг шатах, тослох материал, арчих материалыг хадгалдаг газар, аливаа агуулахад тамхи татаж, ил гал гаргаж үл болно;

4.9.3.Шатах чанартай хийцийн материал бүхий халаалтын, усны, бохирын шугам хоолойг хөлдүү үед халаахдаа ил гал ашиглаж үл болно;

4.9.4.Гал гарсан тохиолдолд энэ тухай удирдлагууд ба гал командад яаралтай мэдэгдэж гал команд ирэх хүртэл галыг унтраах арга хэмжээг авна;

4.9.5. Галын хорны бүтэц, ажиллах зарчмуудыг мэддэг, ашиглаж чаддаг байна;

4.9.6. Гал унтраах хэрэгслийг өөр зорилгоор, зориулалтын бусаар хэрэглэж үл болно.

4.10.Ариун цэвэр, эрүүл ахуйн дараах журмуудыг заавал мөрдөнө. Үүнд:

4.10.1.Зөвхөн зориулалтын төхөөрөмжөөс ус ууна. Техникийн зориулалтаар ашиглагдах усууж үл болно;

4.10.2.Ажлын дараа хорт бодисоор бохирдсон гараараа хоол идэх, тамхи татаж үл болно.

4.10.3.Элдэв хортой бодис агуулагдаж буй газарт хоол идэж, тамхи татаж үл болно.

4.10.4.Ажлын дараа шүршүүрт заавал орно.

Гурав.Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн, бусдад буруу үлгэр дууриалал үзүүлсэн, дээрх аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болон шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд ажилтан, албан хаагч эрсдэлээ бүрэн хариуцна. Мөн ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Галын аюулгүй ажиллагааны дүрэм

1.Шаталтын шинж илэрсэн ба гал гарсан тохиолдолд ажилчин бvр (утаа уугих, утааны vнэр, дулааны хэмийн ихсэлт гэх мэт) дараах vvрэгтэй:
2.584 утсаар ААБОХэлтэст нэн даруй мэдэгдэх (Энэ vед гал гарсан байрлал, мєн тvvнчлэн өөрийн овог нэрийг зайлшгvй мэдээлэх шаардлагатай)

3.Зөвхөн тусгай зориулагдсан байранд тамхи татах ба амархан ноцох, шатах тослох ба арчих материалыг хадгалах байруудад, агуулахуудын талбайд мєн тэдгээр материалтай харьцах vед тамхи татах ба ил гал гаргаж болохгvй.

4.Амархан ноцох шингэнvvдийг саванд дvvргэхдээ энэ ажлыг хийхэд тусгай зориулалтын байранд гvйцэтгэх.

5.Амархан ноцох бодис, мєн тvvнчлэн шатах тослох материалыг зуух, түүдэг асаахад ашиглах, тэдгээрээр халсан ямар нэг гадаргууг угаахыг хориглоно.

6.Асгарсан амархан ноцох шингэнийг хуурай болтол арчих буюу тэр дор нь элс асгаж цэвэрлэх хэрэгтэй.

7.Хэрэглэсэн арчигч материалуудыг тємєр саванд хадгална. Савыг байнга цэвэрлэж байх шаардлагатай. Тос масло арчиж хаясан арчих материал єєрєє ноцох чадвартай байдгийг ямагт санацгаа.

8.Цахилгаан тоног төхөөрөмжийг ашиглах vед хориглох зvйлvvд:

9.Vйлдвэрлэгчийн заавар журамд нийцэхгvй, нөхцөлд ажиллах эсвэл гал гаргаж болзошгvй, гэмтэл бvхий цахилгаан аппарат багаж хэрэгсэл тvvнчилэн гэмтэлтэй болон хамгаалалтын тусгаарлах шинжээ алдсан утас болон кабель;

10.Гэмтэлтэй залгуур, салгуур болон бусад цахилгаан тоноглолын хэрэгслvvдийг ашиглах;

11.Цахилгаан чийдэн, гэрэлтvvлгийг цаасаар, даавуугаар болон бусад шатах материалаар ороохыг, мєн тvvнчилэнтvvний гэрлийн бvрхvvлийг авч ашиглах;

12.Цахилгаан индvv, цахилгаан зуух, цахилгаан данх болон бусад цахилгаан халаагч хэрэгслийг шатдаггvй материалаар хийсэн суурьгvй ашиглах;

13.Телевизор, цахилгаан халаагч болон бусад цахилгаан хэрэгслийн хэмжүүрийг хvчдэлд залгаж удаанаар эзэнгvй орхих;

14.Галын тэсрэх аюултай болон галын аюултай бvс ба агуулахын єрєєг дамжуулан кабелийн шугам, цахилгаан утсыг татах;

15.Зөөврийн цахилгаан гэрэлтvvлэгч нь уян зөөлөн цахилгаан утас хэрэглэсэн, шилэн бvрхvvлээр тоноглогдсон, зvvх дэгээтэй, хамгаалалтын төмөр тортой байх ёстой.

16.Дулааны тохируулагчгvй цахилгаан зуух ашиглахыг хориглоно.

17.Гал унтраах vед гал унтраагуурыг (зориулалтаар нь) ус, элсийг хэрэглэ. (хайрцаг доторхи элс нь хуурай, сийрэг байх ёстой.)

18.Галын анхан шатны багаж хэрэгслийг зориулалтын бус єєр зvйлд хэрэглэхийг хориглоно. (Гал унтраагуур, галын усны хоолой, хувин, хvрз, сvх, элстэй хайрцаг, устай сав.)

19.Гал унтраагуурыг ашиглаж чаддаг байх, тvvний ажиллах зарчим, бvтцийг мэддэг байх.Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл

20.Нүүрсхүчлийн хийн гал унтраагуур

21.Нүүрс хүчлийн хийн гал унтраагуур нь төрєл бvрийн бодис болон материалын шаталтын vед, 1000В хvртэл хүчдэлтэй цахилгаан тоноглолд, хөдөлгvvрийн дотоод шаталтын, шингэн шатахуунд гарсан галыг унтраах зориулалттай



Нүүрсхүчлийн галын хор



Нунтаг галын хор

22.ОУ2, ОУ5, ОУ8 (2л, 5л, 8лийн багтаамжтай) маркийн нvvрсхvчлийн хийн гал унтраагуур нь хийцийн хувьд адил, бvхэл металл ган баллон онгойлгож хаахад зориулсан хаалт, баллон дотор орсон сифон хоолой, цас үүсгэгчийг тэлэгч хоолой, хамгаалах мембран зэргээс бvрдэнэ. Баллон дотор 170 атмийн даралт хvртэл шахсан нүүрсхүчлийн хий дүүргэгдсэн байна.

23.Ажиллах зарчим: Даралттай нүүрсхvчлийн хий сифон хоолойгоор дамжин тэлэгч хоолойд орон цасанцар хэлбэрийн массыг vvсгэн (нүүрсхүчлийн давхар исэл ууршиж орчны температур багасаж цасанцар хэлбэрийн масс vvснэ.) Галын голомтыг бvрхэн хvчилтөрөгчийг тусгаарлаж тэнд хvйтэн орчин vvсч галыг унтраана.

24.Нүүрсхvчлийн галын хорыг ажиллуулах (ОУ2)

25.Гал унтраагчийг авч галын голомтруу аваачин лацыг аван чиглүүлэгч хоолойг галын голомтруу чиглүүлэн түгжээг мулталж ажиллуулах хөшүүргийг атгана.10.11.6 Гал унтраагч ажиллаж байх vед тэлэгчийг (чиглvvлэгч хоолойг) нvцгэн гараар барьж болохгvй. Учир нь хэт хvйтэн

26.Температур vvсч тэлэгчийг ихээр хөргөдөг тул гараа хөлдөөж болзошгvй. Гал унтраагч 23 метрийн зайд 50 сек ажиллана.

27.Нүүрсхүчлийн хий ямарч шаталтыг дэмждэггvй, цахилгаан гvйдэл дамжуулдаггvй учир уг гал унтраагчийг 1000 хvртэл вольтын хvчдэл бvхий цахилгаан утас, цахилгаан тоног

төхөөрөмж гэх мэт агааргүй шатдаг бодисоос (жишээ нь: целлулоид) бусад бvх төрлийн галын голомтыг унтраахад хэрэглэж болно.

28.Нунтаг гал унтраагч ОПУ5, ОПУ10.

29.Нунтаг гал унтраагуурыг 1000 В хvртэл хvчдэлтэй цахилгаан тоноглолд болон хатуу бодис, шингэлэгч бодис, амархан гал авалцан шатах нефть бvтээгдхүүний шаталтын vед гарсан галыг унтраахад хэрэглэнэ.

30.Ажиллах зарчим: Даралттай нүүрсхүчлийн хий (азот) хоолойгоор дамжин гал унтраагуурын их биеийн доод хэсэгт очиж илүүдэл даралтыг vvсгэнэ. Энэ vед нунтаг бодис сифон хоолойгоор дамжин хийн даралтын нөлөөгөөр чиглvvлэгч хоолойгоор гадагш шахагдан гарч галын голомтыг хүчилтөрөгчөөс тусгаарлаж бvрхэн галыг унтраана. Галын хушуу (чиглvvлэгч хоолой) бvхий хааж нээх төхөөрөмжийг атган нунтаг унтраагчийг тодорхой хэмжээгээр өгч болно.

31.Галын хортой ажиллах дvрэм.

32.Галын хорыг халагч хэрэгслийн шууд нөлөөлгvй газар, нарны гэрэл шууд тусахгvй газар байрлуулна.

33.Нунтаг галын хороор цахилгаан тоног төхөөрөмжид гарсан галыг унтраахад 35 секундын зайтайгаар цэнэгийг хувиар өгнө.

34.Шатаж буй цахилгаан тоног төхөөрөмжийн ойролцоо 1 м зайд гал унтраагуурыг аваачихгvй байх

35.Гал унтраагуурын цэнэгийн урсгалыг салхины чиглэлийн дагуу чиглүүлэх

36.Нүүрсхүчлийн гал унтраагуурын чиглүүлэгч хоолойг нvцгэн гараар барьж болохгvй. Учир нь хэт хvйтэн температур үүсч тэлэгчийг ихээр хөргөдөг тул гараа хөлдөөж болзошгvй.

Гурав.Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлсэн, тавьсан шаардлага биелүүлэхгүй байгаа албан хаагч болон ажилтаныг ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 311-р тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Сантехникийн слесарийн мөрдөх аюулгүй ажиллагааны заавар

Нэг. Ерөнхий шаардлага

1.1.Сантехникийн чиг үүрэгт холбогдох ажил үүргийг гүйцэтгэх даалгавар авсан ажилтан Та энэхүү "Сантехникийн слесарийн мөрдөх аюулгүй ажиллагааны заавар №31. НКХАБ–УС–3.031"–ын заалт нэг бүртэй сайтар хичээнгүйлэн танилцаж, зөв хэрэгжүүлэх нь таны гарт байна.

1.2.Сантехникийн чиг үүрэгт холбогдох ажил үүрэг гүйцэтгэгчид нь 18 насанд хүрсэн, эрүүл мэндийн үзлэгт орж тэнцсэн, тусгай мэргэжлийн сургууль, курсийг төгсөж энэ чиглэлээр ажиллах эрх, мэргэжлийн үнэмлэх, сертификат авсан, нийт ажиллагсадын ХАБЭА–н нийтлэг заавар, галын аюулгүй ажиллагааны заавар, анхны тусламжийн заавар, энэхүү зааврaар зааварчилгаа авсан байна.

1.3.Зөвхөн ажлын даалгаврын дэвтэрт тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.4.Шинэ тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хэрэглэх шаардлагатай болсон үед тэдгээр төхөөрөмжийн бүтэц, зохион байгуулалт, ажиллагааны талаар заавал мэдэж ХАБЭА–н давтан зааварчилгаа авбал зохино.

Хоёр. Ажлын байрны зааварчилгаа

2.1.Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ХАБЭА–н талаар хүлээсэн үүргээ сайтар мэдэж, зайлшгүй биелүүлнэ.

2.2.Зөвхөн мастерын даалгасан ажлыг гүйцэтгэнэ.

2.3.Техникийн ашиглалтын дүрэм, замын хөдөлгөөний дүрэм, барилгын талбайгаар зорчих журам, галын аюулгүйн дүрмийг мөрдөж ажиллана.

2.4.Ажлын байр, түүний хаалганы ойр орчимд элдэв материал, эд анги, хог хаягдлыг хөглөрүүлэлгүй ажлын байрны эмх цэгц, цэвэр байдлыг эрхэмлэнэ.

2.5.Ажлын байрны ойр орчим, орох, гарах газруудын шалан дээр аливаа шингэн зүйлийг үл асгана. Ус, тос, шингэн асгарсан байгааг Та харсан бөгөөд эсвэл Та өөрөө тэдгээрийг асгасан бол элс, модны үртэс цацаж элдэв арчих зүйлээр шалыг хаттал арчиж цэвэрлээд, дахин асгарах, гоожихгүй байлгах арга хэмжээг заавал авна.

2.6.Зөвхөн бүрэн, бүтэн, аливаа гэмтэлгүй, шалгагдаж, туршигдан зохих эрх бүхий албан тушаалтны бичгээр өгсөн ажиллуулах зөвшөөрөл бүхий тоног төхөөрөмжөөр ажил гүйцэтгэнэ.

2.7.Ачаа өргөж, буулгах үед заавал дуулга малгай өмсөнө.

2.8.Тоостой орчинд ажиллах үед амны баг заавал хэрэглэнэ.

2.9.Залгуур, гал хамгаалагчийн бүрхүүлийн бүрэн, бүтэн байдлыг заавал шалгана.

2.10.Ажлын байрны гэрэлтүүлэг хангалттай эсэхийг заавал шалгана.

2.11.Аливаа цахилгаан аппарат, тоног төхөөрөмжүүдийн газардуулга, агааржуулах системийн бүрэн, бүтэн байдал, найдвартай ажиллагааг сайтар шалгасны дараа ТА зөвхөн ажлын даалгаварт тусгагдсан ажлыг гүйцэтгэнэ.

2.12.Тоног төхөөрөмжүүдэд аливаа эвдрэл, гэмтэл илэрвэл энэ тухай нэн даруй мастерт мэдэгдэж зохих арга хэмжээг авахуулж, тоног төхөөрөмжийн ажиллагааг туршсаны дараа ажлаа эхлэнэ.

2.13.Ажлын байранд гадны хүн оруулж, байлгаж үл болно.

2.14 Өндөрт ажиллах тохиолдолд хашлага, хамгаалалтууд (шат, тавцан, хөндлөвч)–ыг заавал хэрэглэж тэдгээрийг хөдөлгөөнгүй, бат бэх суурилсан эсэх, түүнчлэн ажиллах газар руу дамжиж очиход тохиромжтой, аюулгүй, найдвартай эсэхийг тус тус шалгана. Хөлтэй тавцан, хөндлөвч тавцангуудын техникийн тодорхойлолт, даацыг заавал мэддэг байна.

2.15.Агаар оруулах, гаргах салхивчны ажиллагаа найдвартай эсэхийг шалгана.

2.16.Ажил эхлэхийн өмнө ажлын даалгаврыг бичгээр авч, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна.

2.17.Ажлын байранд ирээд дараах дүрмийг заавал мөрдөнө. Үүнд:

2.17.1. Ажлын байр, хамгаалах багаж хэрэгслийн бүрэн, бүтэн байдлыг шалгана;

2.17.2. Ажлын багаж хэрэгсэл, механизмын бэлэн байдал, гэрэлтүүлэг хангалттай эсэхийг шалгана;

2.17.3. ХАБЭА–н зөрчил илэрвэл зөрчлийг яаралтай арилгах, хэрэв өөрөө арилгаж чадахааргүй тохиолдолд ажлаа гүйцэтгэлгүйгээр хэсгийн даргадаа мэдэгдэнэ;

2.17.4. Бүрэн зогсоогүй механизм, ус зайлуулах байгууламжийн салгагдаагүй хэсэг дээр ажил гүйцэтгэж болохгүй;

2.17.5. Ус зайлуулах байгууламж, худгийн таг хаалттай эсэхийг хянаж байна;

2.17.6. Ажлын байрны орц, гарцыг элдэв хог, хаягдалгүй, чөлөөтэй байлгана.

2.18.Зөвшөөрөл–нарядаар гүйцэтгэгдэх онц аюултай ажлын жагсаалт, ХАБЭА, экологи, байгаль орчны аюулгүй ажиллагааны ноцтой зөрчилд тооцогдох ажлуудын жагсаалтыг мэддэг байна.

2.19.Тухайн ажлыг гүйцэтгэхийн өмнө ХАБЭА–н зааварчилгаа авч зөвшөөрөл–наряданд гарын үсэг зурж, шаардлагатай багаж хэрэгслийг авах, нарядад бичигдсэний дагуу аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг авч ажлын байрыг бэлэн болгоно.

Гурав. Ажлын гутал хувцас хамгаалах хэрэгсэл

3.1.Ажил гүйцэтгэхдээ улирлын байдалд тохирсон зориулалтын хувцас, гутал өмсөж гүйцэтгэх ажлын онцлогт тохируулан бүрэн, бүтэн хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.

3.2.Зөвхөн нормын дагуу шаардлага хангасан ажлын тусгай хувцастай ажиллана. Хөнгөн гутал (сандааль, гэрийн шаахай, спортын пүүз, кеды г.м) өмсөхийг хатуу хориглоно.

3.3.Ажлын хувцас, гутал, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу зөв хэрэглэнэ.

3.4.Бохирдсон ажлын хувцсыг цаг тухайд нь цэвэрлэгээнд өгнө.

3.5.Өөрт нормын дагуу олгосон ажлын хувцас, гутал, хамгаалах хэрэгслийн бүрэн, бүтэн байдлыг үргэлж анхаарч ажиллана.

3.6.Өөрт тааравгүй томдсон, жижигдсэн, урагдсан, салбарсан, унжсан, санжсан хувцас өмсөж үл болно.

3.7.2м–ээс дээш өндөрт ажил гүйцэтгэхдээ бүрэн бүтэн, туршилт хийгдсэн хамгаалах бүсийг хэрэглэх ба түүнийг ажлын даалгаварт заасан найдвартай тулгуураас бэхэлнэ.

3.8.Толгой хамгаалах дуулга малгайг байнга өмсөж ажил гүйцэтгэх ба дуулга малгайг толгойноос унахаас сэргийлж бүчийг сайтар бэхэлнэ.

3.9.Тусгай зассан талбай байхгүй нөхцөлд өндөрт гарч ажил гүйцэтгэх үедээ доош унахаас сэргийлж хамгаалах бүс хэрэглэнэ.

3.10.Худагт орж ажил гүйцэтгэх үед амьсгалын эрхтнийг хамгаалах хийн баг хэрэглэнэ.

3.11.Хамгаалах хэрэгслүүдийг хэрэглэхийн өмнө тэдгээрийн бүрэн, бүтэн байдлыг гадна үзлэгээр шалгахын зэрэгцээ туршилтын хугацааг заасан пайзаар нь шалгана.

- Хамгаалах бүс, олс 6 сард 1 удаа
- Зөөврийн модон шат 1 жилд 1 удаа

3.12.Засварласан, холбож залгасан аврах олс, мөн олсыг кабель, дамжуулагч утас, төмөр утас, бусад зүйлээр орлуулж ашиглахыг хориглоно.

Дөрөв. Аюул, осол, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх

4.1.Зам, талбайгаар явахдаа явган хүний замаар явах ба хэрэв байхгүй бол авто замын зүүн талыг барьж явна.

4.2.Бүрэн бус багажаар ажил гүйцэтгэж үл болно. Алх, лантууны иш нь цуурч цав гараагүй, гөлгөр гадаргуутай байна. Хуурай, хутга, отвертка нь бариулдаа найдвартай бэхлэгдсэн байна. Эдгээр багажийг бариулгүйгээр ашиглаж үл болно.

4.3. Хориглох зүйлс:

4.3.1.Тухайн ажлыг гүйцэтгэхэд суралцаагүй хүнээр ажил гүйцэтгүүлэх;

4.3.2.Хамгаалах шил зүүлгүйгээр төмөр, металлыг огтлох;

4.3.3.Даралттай хоолойг засварлах;

4.3.4.Хамгаалах бүс зүүлгүйгээр өндөрт ажиллах;

4.3.5.Туршилтын хугацаа нь дууссан, гэмтэлтэй хамгаалах хэрэгслийг ашиглах;

4.3.6.Бичгээр авсан зөвшөөрөлгүйгээр галын ба тэсрэх аюултай газарт галын аюултай ажил гүйцэтгэх;

4.3.7.Шал, тавцангаас 2м–ээс дээш өндөрт хамгаалах хэрэгсэлгүйгээр ажиллах.

4.4. Бичгээр авсан зөвшөөрөл–нарядгүйгээр дараах ажлуудыг гүйцэтгэхийг хориглоно. Үүнд:

4.4.1.Цахилгааны хүчний кабель, ус, уур дамжуулах шугам, дулааны шугам байрласан хэсэгт газар шорооны ажил гүйцэтгэх;

4.4.2.Газар доор ба худагт орж хийж гүйцэтгэх ажлууд, тухайлбал камер, суваг доторх хоолойг засварлах, сүлжээнд гарсан ааварыг устгах.

4.5.Худаг дотор ганцаар ажил гүйцэтгэхийг хориглоно. Газар дээр худгийн ойролцоо хоёр дахь хүн байж ажлын аюулгүй байдлыг хянана.

4.6.Худаг дотор ажил гүйцэтгэж эхлэхийн өмнө шлангтай хийн багийг сайтар шалгасны дараа шлангтай хийн багийг өмсч худаг руу бууна. Шлангын төгсгөл худгийн гадна цэвэр агаар өгөх боломжтойгоор байрласан байна.

4.7. Худаг руу орохын өмнө хамгаалах бүс зүүж, бүсэндээ аврах олсыг бэхлэх ба олсны сул үзүүр худгийн гадна үлдэх 2 дахь ажилчны гарт байна.

4.8. Вентиль, хаалтыг зориулалтын бус багажаар онгойлгох, түлхүүрэнд хоолой, бусад зүйлс залгаж ашиглахыг хориглоно.

4.9. Галын аюулгүй байдлын дараах арга хэмжээнүүдийг мөрдөж ажиллана. Үүнд:

4.9.1.Зөвхөн тусгай зориулалтын газарт тамхи татна;

4.9.2.Амархан шатдаг шатах, тослох материал, арчих материалыг хадгалдаг газар, аливаа агуулахад тамхи татаж, ил гал гаргажүл болно;

4.9.3.Шатах чанартай хийцийн материал бүхий халаалтын, усны, бохирын шугам хоолойг хөлдүү үед халаахдаа ил гал ашиглаж үл болно;

4.9.4.Гал гарсан тохиолдолд энэ тухай удирдлагууд ба гал командад яаралтай мэдэгдэж гал команд ирэх хүртэл галыг унтраах арга хэмжээг авна;

4.9.5 Галын хорны бүтэц, ажиллах зарчмуудыг мэддэг, ашиглаж чаддаг байна;

4.9.6.Гал унтраах хэрэгслийг өөр зорилгоор, зориулалтын бусаар хэрэглэж үл болно.

4.10.Ариун цэвэр, эрүүл ахуйн дараах журмуудыг заавал мөрдөнө. Үүнд:

4.10.1.Зөвхөн зориулалтын төхөөрөмжөөс ус ууна. Техникийн зориулалтаар ашиглагдах ус ууж үл болно.

4.10.2.Ажлын дараа хорт бодисоор бохирдсон гараараа хоол идэх, тамхи татаж үл болно.

4.10.3.Элдэв хортой бодис агуулагдаж буй газарт хоол идэж, тамхи татаж үл болно.

4.10.4.Ажлын дараа шүршүүрт заавал орно.

Гурав.Хариуцлага

Энэхүү аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг санаатай болон санамсаргүй зөрчсөн бусдад буруу үлгэр дууриалал үзүүлсэн, тавьсан шаардлага биелүүлэхгүй байгаа албан хаагч болон ажилтныг ХАБЭА тухай хуулийн 35 дугаар зүйл Засгийн газрын 311-р тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МАРШРУТ**

Хэлтэс, албан тушаал.........................................................

1. Таны яг одоо оршин суугаа хаяг /албан ёсны бүртгэлтэй эсэх нь хамаагүй/
_______________ хот _______________ дүүрэг _________ хороо _________ байр, гудамж №_________тоот хаалга яаралтай үед холбоо барих хүний нэр_______________утас_____________

2. **"ГЭР-АЖИЛ"** замын чиглэлийн болон хугацаа /замд таарах төв зам, тодорхой буудал, томоохон обьектуудыг дараалан бичнэ үү. Жишээ нь: Гэр-Рокмон билдинг-Баруун 4 зам-Их дэлгүүр-Төв зам-Найман зовхис оффис. Нийт явах хугацаа 20-35 мин гэх мэт/

____________________________________________________________

____________________________________________________________

____________________________________________________________

____________________________________________________________

3. **"АЖИЛ-ГЭР"** замын чиглэл болон хугацаа /замд таарах төв зам, тодорхой буудал, томоохон обьектуудыг дараалан бичнэ үү. Жишээ нь: Найман зовхис оффис-Төв зам-Их дэлгүүр-Баруун 4 зам-Рокмон билдинг-Гэр. Нийт явах хугацаа 20-35 мин зарцуулагдана гэх мэт/

____________________________________________________________

____________________________________________________________

____________________________________________________________

____________________________________________________________

**"АЖИЛ- ГЭР" "ГЭР-АЖИЛ"** хэрэв явганаар явж ирдэг бол замын чиглэл болон хугацаа

4. **Таны ажлын цагийн хуваарь** /долоо хоногийн ажлын өдрөөр/

☐ Ажлын 5 өдөр ☐ Ээлжийн ажлын өдөр ☐ Ажлын 7 өдөр

5. Таны ажлын цагийн хуваарь

- ☐ 08:00-17:00
- ☐ 08:00-18:00
- ☐ 08:00-19:00
- ☐ Бусад

*Миний бие _______________(овог, нэр) _______________дээрх мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.*

*Гарын үсэг* __________________ *Огноо* ________________

**САНАМЖ**

*Ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гэмтэл, бэртэл авсан бол "Үйлдвэрлэлийн осол"-д тооцон хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг байгууллага төлнө.*

*Ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гэдэгт-"Ажилтан нь ажлын байрны тодорхойлолтонд тусгасан болон удирдлагын зөвшөөрсөн, даалгасан ажлыг гүйцэтгэх, удирдлагын шийдвэрээр илүү цагаар ажиллах"-ыг тус тус ойлгоно.*

*Мөн "Үйлдвэрлэлийн осол"-д Ажилтан гэрээсээ ажил, ажлаасаа гэр лүүгээ тогтсон чиглэлд тодорхой хугацаанд явж байх үедээ авсан гэмтэл, бэртлийг тооцно.*

*Ажилтан "Гэр-Ажил", "Ажил-Гэр" чиглэлийг энэхүү хавсралтанд үнэн зөв бөглөх бөгөөд оршин суугаа хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Хүний нөөцийн ажилтан / /, ХАБЭА-н ажилтан / /-д мэдэгдэн энэхүү хавсралтыг шинэчлэн байгуулах үүрэгтэй.*

## МАРШРУТ

Хэлтэс, албан тушаал.........................................................

1. Таны яг одоо оршин суугаа хаяг /албан ёсны бүртгэлтэй эсэх нь хамаагүй/
_________________ хот _________________ дүүрэг _________ хороо _________ байр, гудамж №_________тоот хаалга яаралтай үед холбоо барих хүний нэр________________утас_____________
2. **"ГЭР-АЖИЛ"** замын чиглэлийн болон хугацаа /замд таарах төв зам, тодорхой буудал, томоохон обьектуудыг дараалан бичнэ үү. Жишээ нь: Гэр-Рокмон билдинг-Баруун 4 зам-Их дэлгүүр-Төв зам-Найман зовхис оффис. Нийт явах хугацаа 20-35 мин гэх мэт/

______________________________________________________________________________
______________________________________________________________________________
______________________________________________________________________________
______________________________________________________________________________

3. **"АЖИЛ-ГЭР"** замын чиглэл болон хугацаа /замд таарах төв зам, тодорхой буудал, томоохон обьектуудыг дараалан бичнэ үү. Жишээ нь: Найман зовхис оффис-Төв зам-Их дэлгүүр-Баруун 4 зам-Рокмон билдинг-Гэр. Нийт явах хугацаа 20-35 мин зарцуулагдана гэх мэт/

______________________________________________________________________________
______________________________________________________________________________
______________________________________________________________________________
______________________________________________________________________________

**"АЖИЛ- ГЭР" "ГЭР-АЖИЛ"** хэрэв явганаар явж ирдэг бол замын чиглэл болон хугацаа

4. **Таны ажлын цагийн хуваарь** /долоо хоногийн ажлын өдрөөр/

☐ Ажлын 5 өдөр ☐ Ээлжийн ажлын өдөр ☐ Ажлын 7 өдөр

5. Таны ажлын цагийн хуваарь
- ☐ 08:00-17:00
- ☐ 08:00-18:00
- ☐ 08:00-19:00
- ☐ Бусад

*Миний бие ________________(овог, нэр) ________________дээрх мэдээллийг үнэн зөв бөглөсөн болно.*

*Гарын үсэг* ___________________ *Огноо* _______________

### САНАМЖ

*Ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гэмтэл, бэртэл авсан бол "Үйлдвэрлэлийн осол"-д тооцон хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг байгууллага төлнө.*

*Ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гэдэгт-"Ажилтан нь ажлын байрны тодорхойлолтонд тусгасан болон удирдлагын зөвшөөрсөн, даалгасан ажлыг гүйцэтгэх, удирдлагын шийдвэрээр илүү цагаар ажиллах"-ыг тус тус ойлгоно.*

*Мөн "Үйлдвэрлэлийн осол"-д Ажилтан гэрээсээ ажил, ажлаасаа гэр лүүгээ тогтсон чиглэлд тодорхой хугацаанд явж байх үедээ авсан гэмтэл, бэртлийг тооцно.*

*Ажилтан "Гэр-Ажил", "Ажил-Гэр" чиглэлийг энэхүү хавсралтанд үнэн зөв бөглөх бөгөөд оршин суугаа хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Хүний нөөцийн ажилтан / /, ХАБЭА-н ажилтан / /-д мэдэгдэн энэхүү хавсралтыг шинэчлэн байгуулах үүрэгтэй.*